The UTimes
ШИНЭЛЭГ. СОНИРХОЛТОЙ. ҮНЭН

2026 он / № 01

Түсгай дугаар

Парламентын тэмдэглэл

Парламентын ажлыг зөвхөн хэдхэн минутын санал хураалтаар хэмжих боломжгүй юм. Тухайн шийдвэр бүрийн ард олон сарын тооцоо судалгаа, олон талын хэлэлцүүлэг, мэргэжлийн дүгнэлт, иргэдийн санал бодлууд шингэсэн байдаг. Хууль болгон бодит амьдралд тулгарсан асуудлыг шийдвэрлэхийг зорьдог.

Энэ Хаврын чуулганаар миний оролцсон хууль тогтоох ажлууд ийм л зарчимд тулгуурласан билээ. Шинжлэх ухааны хөгжлийг дэмжих, байгаль орчны үнэлгээний тогтолцоог шинэчлэх, байгалийн баялгийн ашиглалтыг ил тод болгох, хүүхдийн хөгжил, эхчүүдийн эрхийг хамгаалах зэрэг эрх зүйн шинэчлэлүүд өөр өөр салбар, чиглэлийг хамарсан ч нэг л зорилготой байлаа. Тэр нь төрийн үйлчилгээг үр ашигтай болгож, хууль эрх зүйн орчны шударга байдлыг бэхжүүлэн, төрийн бодлогыг иргэн төвтэй хөгжүүлэхэд чиглэж байв.

Энэхүү сониноор дамжуулан Танд хүргэж буй мэдээллүүд нь хийсэн ажлын тайлан, жагсаалт гэхээс илүүтэй ямар асуудлыг шийдэхийн төлөө ажиллаж, ямар өөрчлөлтийг эхлүүлснээ тэмдэглэсэн товч тэмдэглэлүүд минь юм. Эрхэм Таныг санал бодлоо харамгүй хуваалцана гэдэгт итгэж байна.

ЭНЭ ДУГААРТ

МЭДҮҮШТЭЙ

Эрдэмтэд улам чадавхжина: Суурь судалгаа, эрдэм шинжилгээний бүтээл нь нээлттэй ашиглагдана

3-7-р нүүрт

УНШУУШТАЙ

Хог хаягдлаа зөв ашиглах боломжтой

8-9-р нүүрт

БОДУУШТАЙ

Asian Women Leadership программ Өмнөговь аймагт хэрэгжив

10-р нүүрт

ХҮСҮҮШТЭЙ

Аялал жуулчлалыг хангалттай хөгжүүлэх боломж бүрэн бий

11-р нүүрт

ХӨГЖҮҮШТЭЙ

Өмнөговь аймагт олон шавь нартай болж байгаадаа баяртай байна

12-р нүүрт

ЗАЛУУ ЛИДЕР

Ээжээс өвлөсөн мэргэжлээр Харвардад хүрч, чанартай гүйцэтгэлээр УИХ-ын гишүүн болсон түүх



“Монголын үнэн” сонин шинэ цагийн, залуу манлайлагчдыг нэрлэн, тэдний амжилтын түүхийг хуваалцах үүднээс “Залуу лидер” буланг эхлүүлж байна. Энэ удаад Харвардад докторын зэрэг хамгаалсан хоёрхон монгол хүний нэг, уул уурхайн салбарын төлөөлөл болсон УИХ-ын гишүүн, Байгалийн ухааны доктор Б.Уянгыг онцолж байна.

МАН-ын залуу гишүүдийн нэг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд гэдгээс өөрөөр, өнөөдрийн нөхцөлд та өөрийгөө хэрхэн танилцуулах вэ?

Өөрт оногдсон ямар ч ажлыг маш сайн гүйцэтгэлтэйгээр давж гарахад хамаг сэтгэл зүрхээ зориулдаг даа. Тэр дундаа улс төрд яваа эмэгтэй хүний хувьд өмнөө тавьсан зорилгоо биелүүлэх, ноогдсон ажлаа цаг тухайд нь чанартай гүйцэтгэхэд гол анхаарлаа хандуулдаг. Эмэгтэйчүүд бол маш их гүтгэлэг, хардалт дунд үйл хэргээ бүтээдэг улс. Гэсэн хэдий ч зорьсон ажилдаа цаг гаргаад, зөвөөр таниулаад явахад бүтэх ёстой гэж бодож явдаг ажил хэрэгч эмэгтэй. Гурван хүүхдийн ээж, айлын эхнэр хүн. Нөхөртөө сайн хань, үр хүүхдүүддээ сайн ээж нь байхын төлөө чадах чинээгээрээ хичээж, хамтран зүтгэж яваа нөхдийнхөө итгэлийг дааж явахад болно гэж боддог.

АНУ-д, тэр дундаа дэлхийн топ сургууль Харвардад суралцсан түүхээсээ бидэнтэй хуваалцана уу?

Би 2010-2016 оны хооронд АНУ-д Харвардын их сургуульд зургаан жил сурч, байгалийн ухааны чиглэлээр докторын зэрэг хамгаалсан. Бакалаврын боловсролыг Монголдоо буюу ШУТИС-д Геологи, уул уурхайн сургуульд сурч, үндсэн мэргэжлээ эзэмшсэн. Геологийн шинжлэх ухаан бол байгалийн ухаан дундаа газрын хэвлий буюу хөрснөөс дооших орон зайг судалдаг мэргэжил л дээ. Миний ээж чулуулгийг нарийн түвшинд нь судалдаг эрдэмтэн хүн байгаа юм. Миний хувьд ээжийнхээ мэргэжлийг өвлөсөн.

Мэргэжил сонголтын тухайд өнөөгийн нөхцөлийг харахаар дунд сургуулиа төгсөж буй залуучууд Монголдоо бакалаврын боловсрол эзэмшилгүйгээр шууд гадагшаа явах хүсэлтэй болж. Өөрийнхөө хүүхдийг харахад ч ийм хандлагатай болчихож. Миний хувьд энэ тухайд өөр бодолтой байдаг. Учир нь манай улсын их, дээд сургуулийн боловсролын чанар муу биш, хаана ч гологдохгүй. Багш сайн байхад сургалтын чанар муу байх ямар ч боломжгүй. Үүнийг амьдралаараа баталсан хүний нэг нь би өөрөө юм. ШУТИС бол дэлхийн хэмжээнд төдийлөн алдартай сургууль биш.

Тийм байхад миний хувьд жишээлбэл АНУ-д, Харвардад суралцахаар шалгалт өгч байх үедээ нэг зүйлийг анзаарсан нь миний Монгол Улсдаа эзэмшсэн бакалаврын суурь боловсрол ерөөсөө гологдохоор хэмжээнд биш юм байна гэдгийг өөрийн биеэр үзэж, мэдэрсэн. Маш олон шалгалт, шат дамжлага даваад Харвардад тэнцэж орсныхоо дараа хичээлүүдээ үзээд эхлэхэд ч манай улсын сургалтын систем муу биш юм байна гэдэгт бат итгэлтэй болсон. Хаана ч явсан ШУТИС гэдэг нэрээр овоглосоор энэ хүрч байна. Ерөөсөө бакалаврын дипломоо хаана хамгаалж, боловсрол эзэмшсэн бэ гэдгээр насан туршдаа овоглож явдаг. Одоо эргээд бодоход ямар азаар Монголдоо, тэр дундаа ШУТИС-д бакалаврын боловсрол эзэмшсэн юм бэ гэж бодогддог. Хаана ч явсан манай сургуулийнхан, төгсөлтийнхөн ажиллаж, салбараа манлайлж явдаг.

Ээж маань салбарын эрдэмтэн учраас “түүний охин”, нөхөр маань мөн энэ салбарынх учраас “түүний эхнэр” гэх мэтээр бүхэл бүтэн хүрээлэлтэй. Энэ нь нөгөө талдаа намайг салбартаа хүлээн зөвшөөрөгдөхөд маш том хөшүүрэг, дэмжлэг байсан.

Үргэлжлэл нь 2, 3 дугаар нүүрт

The UTimes
ШИНЭЛЭГ. СОНИРХОЛТОЙ. ҮНЭН

Дэлгэрэнгүйг эндээс

ЗАЛУУ ЛИДЕР

Ээжээс өвлөсөн мэргэжлээр Харвардад хүрч, чанартай гүйцэтгэлээр УИХ-ын гишүүн болсон түүх

Түрүүч нь 1 дүгээр нүүрт

Тиймээс дунд сургуулиа төгсөж бүй залуучууд хүүхдүүд маань эхлээд эх орондоо суралцаж, суурь боловсролоо эзэмших нь хамгийн сайн сонголт байж болох юм шүү гэж хэлмээр байна. Ядаж эхний хоёр жилдээ Монголдоо сурч, хүмүүжиж, найз нөхдийн хүрээлэлтэй болох нь хожмын амьдралд тань томоохон дэм, хөшүүрэг болдог юм шүү. Дараа нь гадагшаа сурч боловсрох бүрэн боломж бий шүү дээ. Хамгийн чухал нь хаана ч сурч боловсорсон эргээд заавал эх орондоо ирж ажиллаж, амьдрах хэрэгтэй шүү гэдгийг онцолъё.

Харвард бол дэлхийн номер нэг сургууль гэдэг утгаараа маш хүнд шалгуур, давааг давж байж элссэн. Тухайн үед хүмүүс “Ямар азтай юм бэ” гэдэг, би өөрөө ч азтай учраас ийм шилдэг сургуульд элсэн суралцаж байна гэж боддог байлаа. Гэтэл яг үнэндээ аз зүгээр сууж байхад ирдэггүй. Маш олон хоногийн нойр, хичээл зүтгэл, чармайлтын үр дүн байж таарна шүү дээ. Одоогийнх шиг технологи хөгжөөгүй учраас бүх зүйл дээр бүтээмж шаардана. Эссэгээ гараар бичихээс авхуулаад олон өдөр хоногийн шаргуу хөдөлмөрийн үр дүнд дэлхийн топ сургуульд орж чадсандаа одоо бахархдаг. Тэр дундаа өөрийн эзэмшсэн бакалаврын боловсролыг байгаль орчны чиглэлээр улам гүнзгийрүүлэн суралцах боломжтой болсноор зургаан жилийн хугацаанд шамдан суралцаж байж докторын дипломоо гардсан. Ер нь Монгол Улсаас Харвардад докторын зэрэг хамгаалсан хоёр л хүн бий. Эхнийх нь антрополигич эмэгтэй бий. Хоёр дахь нь би. Ямартаа ч докторын түвшний судалгаа хийж, Харвардад монгол хүн сурч боловсрох замыг эхлүүлж шан татаж, бас дуусгаж чадсан. Цаашдаа олон монгол хүн энэ сургуульд сурч, дэлхийн түвшний боловсрол эзэмшинэ гэдэгт итгэлтэй байдаг.

Амьдралдаа хийсэн хамгийн зөв сонголт тань юу вэ?

Том хүүгээ төрүүлсэн маань миний амьдралдаа хийсэн хамгийн зөв сонголтын нэг гэж итгэлтэйгээр хэлнэ. Гадаадад сургуульд явахаасаа өмнө ээж болсон хэрэг л дээ. Тухайн үед гадагшаа сургуульд явах том боломжтой зэрэгцэж ирсэн хүүгээ тээж төрүүлэхээр шийдсэн маань гэр бүлийн амьдралаа алдахгүй авч явах хамгийн чухал шийдвэр, алхам байж дээ гэж одоо боддог. Хэрвээ би тухайн үед гэр бүл зохиогоогүй, хүүхэд төрүүлээгүй байсан бол магадгүй тэр чигээрээ ганц биеэр явчих байж дээ гэж боддог юм. Харвардад зургаан жил сурсныхаа дараа Японд очиж ажилласан л даа. Тиймээс ийм завгүй хэмнэл дунд гэр бүлийн амьдралыг хойш тавих, дахиад хоёр хүүхэд төрүүлэхгүй байсан болов уу. Тэгэхээр хүүгээ төрүүлж, хувийн амьдралаа зэрэгцүүлж авч явах эхлэл суурь нь хүү маань байсан учраас хамгийн зөв сонголт гэж хэлнэ. Хувь хүн талаас хамгийн зөв сонголт маань энэ байсан.

Ажил талаасаа ээжийнхээ мэргэжлийг өвлөсөн маань миний амьдралдаа хийсэн зөв сонголтуудын нэг. Намайг дунд сургуулиа төгсөх үед 2-3-хан мэргэжлийг л топ гэж үздэг, бүгд л аль нэгийг нь сонгодог байлаа шүү дээ. Тоонд сонирхолтой байсан учраас эдийн засагч болно гэж боддог байсан л даа. Тухайн үед гайгүй сурдаг хүүхдүүд эдийн засагч, хуульч, эмч гурвын нэгийг сонгодог байлаа. Эмч мэргэжлийг бол сонирхоогүй, үлдсэн хоёр сонголтыг сонирхож байсан ч багаасаа ээжийгээ харж, мэргэжлийг нь сонирхож өссөн учраас уул уурхай, байгаль орчны чиглэлээр суралцах сонголтыг хийж байлаа. Ээж маань судлаач хүн учраас аливаа зүйлийг тайлбарлаж өгөхдөө шинжлэх ухаанчаар хандаж, ойлгуулдаг байсан юм. Тэр зан нь надад их нөлөөлсөн учраас ээжийнхээ мэргэжлийг өвлөсөн гэж боддог юм. Энэ нь эргээд өнөөдөр миний амьдралыг тодорхойлох суурь том сонголт байсан.

> *… Сургуулиа төгсөж буй залуучууд хүүхдүүд маань эхлээд эх орондоо суралцаж, суурь боловсролоо эзэмших нь хамгийн сайн сонголт байж болох юм шүү …*

Гурван хүүхэдтэй ээж хүний хувьд ажил, амьдралын тэнцвэрийг хэрхэн хангаж байна вэ?

Өөр сонголт байхгүй гэдэг үүднээс бүх зүйлээ зохицуулж амьдардаг. Хүүхэд төрүүлсэн бол өсгөх ёстой, сургуульд орсон бол төгсөх ёстой гэдэг хандлагатай. Надад өөр сонголт байхгүй гэж бодох нь амар байдаг л даа. Яаж ийгээд л гаргалгаа нь гараад ирдэг. Өглөө ажилдаа явахаас өмнө



Үе үеийн Геологийн бодлогын газрын дарга Д.Ганбат, Б.Баатарцогт, Б.Мөнхтөр нарын хамт

хүүхдүүдээ хооллож, угаалгын машинаас хувцсаа гаргаж тохдог зураг шиг угаасаа л амьдрал ийм, болгох л ёстой гээд хүлээн зөвшөөрчих нь илүү амар гэж боддог. Мэдээж улс төрд яваа эмэгтэйчүүдийн хувьд нөхрийн дэмжлэг маш чухал. Тиймээс хань ижилтэйгээ маш сайн ойлголцоно. Миний хувьд бол ээжийгээ л маш завгүй амьдруулж байна даа. Хожим хоёр охиныхоо хүүхдийг харна л гэж боддог. Хийх ёстой бол хийнэ.

Таны ажил, амьдралдаа баримталдаг зарчим?

Цаг маш сайн барьдаг. Цагийн юм цагтаа. Энд тэнд очоод хүн хүлээгээд байх дургүй. Бусдын цагийг хүндэтгэдэг байх хэрэгтэй шүү дээ.

УИХ-ын гишүүн болохоос өмнөх таны карьертай танилцъя?

УИХ-ын гишүүний ажил бол сонгуульт албан тушаал шүү дээ. Одоо эргээд бодоход миний сонгуульт ажил их эрт эхэлсэн гэж боддог. ШУТИС-ийн гуравдугаар дамжаанд суралцаж байхдаа сургуулийнхаа Оюутны холбооны тэргүүнээр сонгогдож байлаа. ШУТИС-ийн оюутны холбооны тэргүүний албыг бүтэн жилийн хугацаанд хашсан. Тухайн үед манайх 13 салбар сургуультай, сургууль бүр нь Оюутны зөвлөлтэй байсан юм. Ингээд үндсэндээ мини Засгийн газрын зарчмаар ажилладаг байлаа. Улс төрд явах бэлтгэл суурь ингэж, оюутан байхдаа тавигдсан гэж үздэг. Оюутны холбооны тэргүүнээр ажиллахад мөрийн хөтөлбөр дэвшүүлнэ, илтгэлээ тавина, сонгогдоно. Ажлаа хүлээлгэж өгөхдөө тайлангаа тавина гээд бүх процесс сонгуулийн зарчмаар өрнөдөг.

Би одоо ажлынхаа хажуугаар оюутан залуучуудтайгаа их уулздаг л даа. Ингэхдээ “Та бүхэн минь хичээлдээ шамдан суралцахаас гадна нийгмийн идэвхтэй байгаарай, олон нийтийн ажилд аль болох оролцдог байгаарай” гэж захидаг. “Үнэн” сонины уншигч залуучууд маань ч гэсэн зөвхөн ном шагайхаас гадна хүмүүст өөрийгөө ойлгуулж сурахын тулд нийгмийн идэвхтэй байгаарай гэж хэлэх байна. Миний хувьд аль эрт буюу 20 настай байхаас сонгуульт ажлын суурь тавигдаж байж дээ гэж боддог.

Сургуулиа төгсөөд салбартаа, хувийн хэвшилд 2010 он хүртэл “Монголиан Минерал Эксплорэйшн Саппорт” ХХК болон “Рио Тинто Монгол” ХХК-д судлаач геологичоор ажиллаж байгаад АНУ-д суралцахаар явж байсан юм. Харвардад зургаан жил суралцаж төгсөөд шууд Японд очиж байв. Японы Токиогийн их сургуулийн шинжлэх ухаан, одон орны судлалын тэнхимд судлаачаар ажиллаж байгаад эх орондоо ирсэн. 2020 онд Монголд ирснээсээ хойш ШУТИС-д, дараа нь 2020 оноос хойш төрд ажилласан байна. Үндэсний геологийн албанд дэд дарга, ерөнхий геологичоос Уул Уурхай, хүнд үйлдвэрийн яамны Геологийн бодлогын газрын дарга, түс яамныхаа сайдын зөвлөх, дэд сайдаар ажиллаж байгаад 2024 оны УИХ-ын сонгуулиар МАН-ын жагсаалтад багтсанаар УИХ-ын гишүүнээр ажиллаж байна. Хувийн хэвшилд төдийгүй төрийн байгууллагад ажилласан туршлагатай. Одоо бол хууль тогтоох байгууллагад ажиллаж байна.

УИХ-ын гишүүн бол төрийн захиргааны ажлаас өөр. Энд нэг хүний шийдвэр гэж байхгүй. Дандаа хамтын шийдвэр гардаг. Өөрийнхөө үзэл бодлыг нээлттэй хэлж ярьж байж мэтгэлцээний зарчмаар хэлэлцэж зөв шийдвэр гарах ёстой. Миний суурь хүмүүжил бол аливаа асуудлыг дангаар бус дор хаяж хоёр ба түүнээс дээш буюу олуулаа ярилцаж байж шийдэл гаргах нь илүү үр дүнтэй гэдэгт итгэлтэй байдаг. Энэ ч утгаараа 2024-2028 оны парламент 126 хүний бүрэлдэхүүнтэйгээр, хамтын шийдвэр гарган ажиллаж байна. Үүнээс өмнө Ажлын хэсэг дээр мэргэжлийн судлаачдын оролцоотой маш их хэлэлцүүлэг өрнөдөг. Ингэж байж Байнгын хороо, цаашлаад чуулганаар аливаа шийдвэр эцэслэж гардаг. Гэтэл энэ бүх процессын ердөө арав хүрэхгүй хувь нь л нийгэмд гарч, мэдээлэгддэг. Миний хэлэх гэсэн санаа бол аливаа хууль, тогтоомж УИХ-аар эцэслэгдэж гарахдаа тийм ч амархан гарчихдаггүй. Мэргэжлийн баг хамт олон, олон шат дамжлагаар, тал бүрээс нь хэлэлцэж ярилцаж байж эцэслэдэг гэдгийг хэлэх гэснийх. Парламентын үйл ажиллагааг шүүмжлэх амархан. Гэтэл цаана нь хамтын тоглолт өрнөдөг юм шүү гэдгийг л ойлгох хэрэгтэй байгаа юм.

МАН-ын жагсаалтад орох саналыг анх хэрхэн хүлээн авч байсан бэ?

Миний ээж Өмнөговь аймгийн Цогтцэций сумын харьяат хүн. Аав маань Өвөрхангай аймгийн Уянга сумын харьяат. Хоёулаа л уул уурхай хөгжсөн нутаг. УИХ-ын 2024 оны сонгуулийн өмнө би Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайдаар ажиллаж байсан үе л дээ. Дэд сайдаар ажиллах гэдэг нь улс

төрд орох замналаа эхлүүлээд явж байна гэсэн үг гэдгийг би хувьдаа ухамсарлаж байсан. “Чи өөрөө энэ салбарын хүн учраас уул уурхай хөгжсөн, ээжийнхээ төрсөн нутаг Өмнөговьд ажиллаад ир” гэдэг даалгаврыг намаас өгч, тус аймгийг бүтэн тойрч ажиллаж байлаа. МАН бол институтчилэгдсэн нам учраас хүний нөөц сайтай. Боловсон хүчний судалгааг олон талаас, олон янзаар хийдэг. Үүний үндсэн дээр сонгууль дөхөх үед намын даргаас, хамт олноос МАН-ын жагсаалтад оруулах шийдвэр гарсныг мэдэж байлаа. Маш их потенциальтай том намын жагсаалтад багтахуйц, тэдэнд тоогдохуйц хэмжээнд байсан гэж үзээд жагсаалтад орох саналыг баяртайгаар хүлээн авч байсан. Мэдээж үүнийг дагаад том хариуцлага оногдож байгааг алхам тутамдаа ухамсарлаж ажилладаг. МАН-ын Бага хурлын шийдвэр гарч, жагсаалтыг зарлахад дандаа улс орны тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хэрэгтэй, нарийн мэргэжлийн, салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн хүмүүсийг багтаасан шүү дээ. Миний хувьд мэдээж уул уурхайн салбарынхны төлөөлөл болж, жагсаалтад багтсан. Түхайн үед намаараа бахархсан. Энэ бол нэг талдаа маш том зориг байсан. Маш олон том улстөрч “Нарийн мэргэжлийн, салбарын хүмүүс нь жагсаалтдаа ор, бид тойрогтоо явъя” гэж биднийг хүлээн зөвшөөрснөөр сонгуульд орж байлаа. Энэ бол МАН-ын холын хараа байсан гэж хувьдаа дүгнэдэг.

Манай улс уул уурхайн салбараас өндөр хамааралтай учраас өндөр хүлээлттэйгээр жагсаалтад орсон гэж ойлгодог. Уул уурхайн салбар эдийн засагт маш өндөр хувийн жин дардаг. Гэтэл энэ нь сайрхаж ярих зүйл ерөөсөө биш л дээ. Бид эдийн засгаа солонгоруулах ёстой. Алийн болгон уул уурхайгаас бүрэн шахуу хараат явах вэ. 1990-ээд оны үед Монгол Улсын эдийн засгийн уул уурхайн хамаарлыг судлаад үзэхэд 50+ хувьтай гарч байсан бол өнөөдөр 90+ хувьд хүрчихсэн байна. Хэдийгээр бид энэ хамаарлын хувийг нэг амьсгаагаар буулгаж чадахгүй ч 2024-2028 оны парламент уул уурхайгаа дагуулж эдийн засгаа солонгоруулах алхмыг хийх шаардлагатай. Үүнээс авхуулаад салбарт хийх ажил маш их бий.

УИХ-ын гишүүн болсноос хойш таны амьдралын хэмнэлд ямар өөрчлөлт гарсан бэ?

Амьдралын хэмнэл их өөрчлөгдсөн. Цаг хугацаа маш хурдан өнгөрдөг болсныг мэдэрч байна. Нэг мэдэхэд өглөө, нэг мэдэхэд орой болсон байх жишээний. УИХ-ын гишүүн болсноос хойш хоёр жилийн дараа бүр илүү мэдэрч байна. Бүх ажил хуваарьтай. Хуваарь дуусахад л орой болсон байдаг. Дээр нь маш их энерги зарцуулж байна. Миний хэлж буй үг, ажиллаж буй төсөл бүрийн цаана асар өндөр хариуцлага байдаг учраас өөрийн эрхгүй энергиэ бүрэн зарцуулж ажиллаж байна. Гэлээ гээд ажилдаа, амьдралдаа ч хийх ёстойгоо хийнэ, өөр сонголт байхгүй. Миний хувьд гэртээ хүлээдэг ганц үүрэг нь хүүхдүүдийнхээ хичээлийг хийлгэдэг. Амьдралын хэмнэл өөрчлөгдсөнийг саяхан нэг зүйл дээр анзаарлаа л даа. Хүүхдүүдийн анги, сургууль бүр фэйсбүүк групптэй. Тэнд өрнөж буй аливаа зарлал, мөнгө хураах ажилд хамгийн сүүлд хариу өгдөг болчихсон байх жишээний. Утасны мессэж маш ихээр хураагдсан гэх мэтээр цагийн хомсдолд их ороод байгаагаа мэдэрдэг болсон.

Таны өдөр тутамдаа тогтмол хэрэглэдэг аппликейшн, тоног төхөөрөмж юу вэ?

Хувийн компьютерээ бол байнга ашиглаж байна даа. Гар утас мэдээж хэрэглэгддэг. Аппликэйшн нь Вайбэр, МАН бүлэг апп, Instagram, Eparent байна даа.

Өдөр тутмын хэрэглээндээ ямар программ ашиглаж байна вэ?

Микрософтын албан хэрэгцээ-ний программууд, фигма гэх мэт байна.

Ямар ч ажилтай байсан өөртөө хэвшүүлсэн дадал тань юу вэ?

7 хоногт 3 удаа гадаа гүйдэг. Өвлийн хүйтэн байсан ч гүйдэг дээ.

Өдөр тутмын мэдээ мэдээллийг хаанаас, ямар сувгаас авдаг вэ?

Ажлын өдрүүдэд бол Parliament.mn хамгийн бодитой мэдээ өгдөг гэж боддог. Хүндэлдэг улстөрчдийнхөө сошиал хаягийг дагадаг. Гадаад мэдээг Economist сэтгүүлээс уншдаг.

> *... Манай улс уул уурхайн салбараас өндөр хамааралтай учраас өндөр хүлээлттэйгээр жагсаалтад орсон гэж ойлгодог ...*

Уул уурхайн салбарын төлөөлөл болсон хүний хувьд УИХ-ын гишүүнээр ажиллаж буй цаг хугацаагаа хэр үр дүнтэй өнгөрүүлж байна вэ?

Салбар яаманд төрийн захиргааны ажилтан байхдаа л уул уурхайн салбарын талаар ташаа ойлголт нийгэмд түгдэг байдлыг ойлгосон. Тийм ч учраас эхний ээлжинд Улсын Их Хурлын гишүүнээр ажиллах хугацаанд байгалийн баялагтай холбоотой зөв мэдээллийг өгөх ёстой гэж бодсон. Хүний мэдэх эрхэд балмадаар халдаж, уул уурхайн салбарын талаар тэс хөндлөн зүйл яриад байдагт маш их харамсдаг байсан. Энэ нь сошиалын бүруу хэрэглээнээс ихээхэн хамаарч байна. Тийм ч учраас төрд ажиллаж байхдаа энэ салбарын талаар зөв ойлголт өгөх талын ажлыг нэлээд хийдэг байлаа. Одоо ч гишүүнээр ажиллах хугацаандаа энэ ажлаа үргэлжлүүлж байна. Жишээлбэл, хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаа гэдэг түсдаа ойлголт. Уул уурхайн олборлолт бол байгалийн баялгийг ашиглаж байгаа хэлбэр гэх мэтээр ярих бүрдээ салбарын талаар зөв мэдээлэл, ойлголт өгөхийг зорьдог.

УИХ-ын гишүүн болж орж ирснээс хойш нэг хуулийн төсөл дээр тухайлан ажилласан. Энэ нь Чухал ашигт малтмалын төслийг дэмжих тухай хууль. Өнөөдрийн Ашигт малтмалын тухай хуульд 2006 онд батлагдсан цагаас нь эхлэн маш олон нэмэлт, өөрчлөлт оруулсаар үндсэн үзэл баримтлал нь алга болчихсон. Тиймээс энэ хуулийг сайжруулах шаардлага үүссэн байсан. Шинэ тутам үүссэн харилцааг зохицуулахын тулд аливаа хуулийг шинэчлэх ёстой шүү дээ. Дэлхий даяар ашигт малтмал, уул уурхайн салбарт юу шинээр үүссэн бэ гэхээр чухал ашигт малтмал, газрын ховор металлын хэрэглээ. Бидний хэрэглэж буй утас, компьютероос авхуулаад технологи улам бүр нарийсан хөгжиж байна. Гэтэл үүнд хэрэгтэй эрдэс баялгийн эрэлт ихэсчихсэн. Нэг хэсэг дулаан цахилгаан үйлдвэрлэхэд нүүрс маш их эрэлттэй байлаа. Гэтэл өнөөдөр энэ нь цэвэр эрчим хүч рүү шилжчихлээ. Цахилгаанаа хураах шаардлага үүсчихлээ шүү дээ. Цахилгаан хураах технологид газрын ховор элемент, батарейн түүхий эд хэрэгтэй болж эхэлж байна. Тиймээс энэ шинэ тутам үүсэж буй харилцааг хуульд оруулж, тусгах ёстой.

Нөгөө талаас уул уурхайн салбарт төрийн оролцоо маш их байгаа тухайд суурь судалгаа хийлгүүлсэн. Энэ судалгааныхаа хүрээнд Чухал ашигт малтмалын тухай хуулийн төслийг санаачлан боловсруулсан юм. Г.Дамдинням сайд ажлаа хүлээж авснаас хойш Ашигт малтмалын тухай хуулийн явц маш эрчимжиж эхэлсэн учраас УИХ-ын гишүүдэд олгодог бүх санхүүжилтээ зарцуулж хийлгэсэн нарийн судалгаагаа бүгдийг нь засаг руу шилжүүлсэн. Түүнчлэн байгалийн нөөц ашиглалт ил тод биш учраас аливаа хардалт өрнөж, авлига хүнд суртлын асуудал үүсгээд, гүтгэлэгт өртөөд, шүүхийн шатанд маш олон хүний нэр хүндэд халдах асуудал үүсдэг гэдэг үүднээс Байгалийн нөөц ашиглалтын ил тод байдлын тухай хуулийн төсөл дээр мөн ажиллаж байна. Энэ хүрээнд ан амьтан агнах зөвшөөрлийг хүртэл ил болгох шаардлагатай гэж үзэж байгаа юм. Ингэж байж аливаа хардалт сэрдэлтгүй болсноор хаана хаанаа зөв ойлголттой болох юм.

Түүнчлэн байгаль орчны нөлөөллийн үнэлгээний Ажлын хэсгийг ахлан ажиллаж байна. Ажиллах явцдаа анзаарсан зүйлээс ганц жишээ татахад, манай гишүүд “Уул уурхайн салбар бол байгаль орчны эсрэг” гэж яриад байх юм. Гэтэл байгалийн баялгийг эдийн засгийн эргэлтэд оруулж байгаа нь уул уурхайн салбар шүү дээ. Байгалийн баялгийн ашиглалт гэдгийг хаана хаанаа ойлгочихмоор байгаа юм. Энэ тухайд ерөөсөө л зохистой ашиглалт, эргээд нөхөн сэргээлт гэдэг ойлголт байх учиртай.

Монголын Үнэн сонины
5 дугаар сарын 1-ний дугаараас...

Мэдүүштэй

Эрдэмтэд улам чадавхжина: Суурь судалгаа, эрдэм шинжилгээний бүтээл нь нээлттэй ашиглагдана

“Шинжлэх ухаан, технологийн тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг УИХ-ын гишүүн Болдын Уянга миний бие Д.Рэгдэл, Г.Хосбаяр нарын гишүүдийн хамтаар санаачилж, боловсруулсан. Нэмэлт, өөрчлөлт оруулах болсон үндсэн шалтгаан нь “Шинжлэх ухаан, технологийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэхэд дараах асуудлууд үүссэн байсан. Тодруулбал,

1. Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага тухайн байгууллагын судалгааны үндсэн чиглэлээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсан сонгон шалгаруулалтад оролцоход тендерийн болон гүйцэтгэлийн баталгаа шаардахтай холбоотой санхүүгийн боломжгүй байдал.

2. Төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн /суурь/ судалгааны ажлыг нэг дор төвлөрүүлсэн дата бааз бий болоогүй. Үүнээс үүдэн судалгааны ажлыг давхардуулан хийж, төсвийн үргүй зардал гардаг явдал байв.

Өөрөөр хэлбэл, төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагууд төрийн худалдан авах ажиллагаанд оролцоход “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу тендерийн баталгаа бүрдүүлэн оролцох шаардлагатай болдог. Шалгарсны дараа тус хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг шаарддаг нь тендерт оролцох нөхцөл, боломжийг хязгаарладаг.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 31.5-д “Засгийн газар, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь энэ хуулийн 3.1.11-т заасан судалгааны үндсэн чиглэлээр шинжлэх ухаан, технологийн төсөл, суурь судалгаа, хэрэглээний судалгаа, технологийн туршилт-



зүгшрүүлэлтийн ажлыг төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлэх харилцаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль хамаарахгүй” гэж заасан байдаг. Гэвч уг зохицуулалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн болон зохион байгуулалтын механизм тодорхой бус, захиалагч байгууллагуудын практик хэрэгжилт харилцан адилгүй байснаас дээрх зохицуулалт бүрэн хэрэгжих боломж хязгаарлагдмал хэвээр байв.

Үргэлжлэл нь 4 дүгээр нүүрт

The UTimes
ШИНЭЛЭГ. СОНИРХОЛТОЙ. ҮНЭН

Дэлгэрэнгүй эндээс

А Эрдэмтэд улам чадавхжина: Суурь судалгаа, эрдэм шинжилгээний бүтээл нь нээлттэй ашиглагдана

Түрүүч нь 3 дугаар нүүрт

Түүнчлэн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.4.26, 8.4.27-д мэдээлэл хариуцагч нь төсвийн хөрөнгө болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүнгийн талаарх мэдээлэл, мөн өөрийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайланг байнга ил тод, нээлттэй байлгах үүрэгтэй гэж заасан ч энэхүү шаардлага практикт нэг мөр хангагдахгүй байсан. Улмаар төрийн санхүүжилтээр хэрэгжсэн судалгаа, шинжилгээний ажлын мэдээллийн хүртээмж, ашиглалт, үр өгөөж хангалтгүй, судалгааны үр дүнгийн ил тод байдал, хариуцлагын тогтолцоог сайжруулах шаардлага үүссэн байв.

Хууль өргөн баригдсаны дараа Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд хуваарилагдсан ба Улсын Их Хурлын байнгын хороо болон нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэх хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг УИХ-ын гишүүн С.Зулпхар ахлан ажилласан.

Ажлын хэсэгт А.Ариунзаяа, Ц.Баатархүү, Д.Бум-Очир, Ж.Галбадрах, Д.Ганмаа, О.Саранчулуун, С.Эрдэнэбат нарын гишүүд ажилласан ба үйл ажиллагаа явуулж буй эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдэд очиж, идэвхийлэн ажилласанд их талархсан. Ингээд үр дүн гарав. Хуульд нэмэлт, өөрчлөлт орж, 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдөр эцэслэн батлагдсан.

Цаашдаа төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагууд төсвийн мөнгөөр хийгдэх суурь судалгааны сонгон шалгаруулалтад оролцох боломжтой боллоо. Оролцоод шалгарвал, тендерийн баталгаа гаргахгүй тул судалгаагаа чөлөөтэй хийх боломжтой боллоо. Монгол олон эрдэмтэд олон улсад нэрээ чанга дурдуулсан мундаг эрдэмтэд болно гэдэгт итгэлтэй байна.

Энэ нь төрөөс санхүүжүүлж буй судалгаа, шинжилгээний ажлын хэрэгжилтийг бодитой дэмжиж байгаа нэг хэлбэр бөгөөд судалгааны үр дүнгийн ил тод, нээлттэй байдлыг мөн хангаж байгаа нь үр дүнг иргэд нээлттэй ашигладаг болно гэсэн үг юм. Эдийн засаг, хөгжлийн яам болон Боловсролын яамныхан энэхүү хуулийн зохицуулалтыг амжилттай хэрэгжүүлэхийг хүсье.

Б Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний чиглэлээр төрийн байгууллага илүү хариуцлагажиж, шаардлагагүй бичиг цаасыг цөөлөв

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль” 2012 онд батлагдсан байдлаараа дагаж мөрдөгддөг. Үнэлгээ хийхдээ дагаж мөрдөх бүх төрлийн процессыг хуульчилсан хууль байдаг. Энэ хуульд асуудал байгааг 10 гаруй жил судалж, мэдээлэл цуглуулсаар 2022 онд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны хамт олон нэмж, өөрчлөх хэрэгтэй байна гэж үзэж салбарын хэмжээнд хэлэлцүүлэг өрнүүлсэн байдаг. Нэлээд бэлтгэл хангасны эцэст 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Хуулийн төсөл Байгаль орчин, хөдөө аж ахуйн байнгын хороонд хуваарилагдсан ба Байнгын хорооны тогтоолоор УИХ-ын гишүүн Болдын Уянга миний бие ахлан ажиллаж, Н.Алтаншагай, П.Батчимэг, Б.Бат-Эрдэнэ, С.Замира, Ц.Идэрбат, Ц.Мөнхбат, Б.Мөнхсоёл, С.Одонтуяа нарын гишүүдийн бүрэлдэхүүнтэй Ажлын хэсгийн хүрээнд төрийн байгууллагууд, эрдэмтэн судлаачид, мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгж, байгууллагуудын саналыг түсгасан эсэхийг нягталж, Дундговь болон Говьсүмбэр аймгийн зарим сумдаар хэлэлцүүлж, саналыг авч ажилласан.

Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагыг дараах байдлаар дүгнэн хэлж болно. Үүнд:

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тогтолцоо нь аливаа төсөл, бүтээн байгуулалт, байгаль орчинд ямар нөлөө үзүүлэхийг урьдчилан тооцоолж, сөрөг нөлөөллийг бууруулах зорилготой. Гэвч хэрэгжилтийн явцад үнэлгээний шат дамжлага олон, хугацаа урт, шаардлагууд давхардсан, зарим зохицуулалт ойлгомжгүй болсон талаар бизнес эрхлэгчид төдийгүй төрийн байгууллагууд удаа дараа хөндөж ирсэн.

Түхайлбал эрсдэлийн түвшин харилцан адилгүй төслүүдэд ижил төрлийн үнэлгээний шаардлага хангуулахаар заасан нь жижиг, дунд бизнес эрхлэгчдэд илүү хүндрэл учруулдаг байв. Иймээс үнэлгээний тогтолцоог эрсдэлд суурилсан зарчимд шилжүүлэх шаардлага бодитоор үүссэн.

Хуулийн хамгийн чухал өөрчлөлтийн нэг нь төслүүдийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн эрсдэлийн түвшингээр нь ангилан үнэлэх зохицуулалт юм. Энэ нь байгаль орчинд бага нөлөөтэй үйл ажиллагаанд хэт их хугацаа, зардал зарцуулахгүй байхаар зохицуулж өндөр эрсдэлтэй төсөлд илүү нарийвчилсан үнэлгээ хийх боломжийг бүрдүүлсэн. Энэ нь төрийн байгууллагуудын хяналт шалгалтыг илүү оновчтой болгож, бодит эрсдэлтэй асуудалд төвлөрөх нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзэж байна.

Зарим иргэний нийгмийн байгууллагаас үнэлгээний шаардлагыг хөнгөвчилснөөр байгаль орчинд учрах эрсдэл нэмэгдэх эсэх асуудлыг хөндөж байгаа учраас тайлбар өгөх нь зүйтэй болов уу.

Байгаль орчинд үзүүлэх нөлөө өндөр эрсдэлтэй төслүүд хатуу хяналтад хэвээр байна, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний ач холбогдлыг нэмэгдүүлнэ, байгаль орчны мониторингийн тогтолцоог боловсронгуй болж нөхөн сэргээлт, хамгаалалтын үүргийг тодорхой болгоно. Ингэснээр байгаль



хамгаалах бодлогын үндсэн зарчим өөрчлөгдөхгүй бөгөөд хэрэгжилтийн чанар сайжрах нөхцөл бүрдэх юм.

Түүнчлэн, байгаль орчны үнэлгээтэй холбоотой хамгийн чухал асуудлын нэг нь орон нутгийн иргэдийн оролцоо байдаг. Хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр төсөл хэрэгжих бүс нутгийн иргэд мэдээлэл авах, санал гаргах, хэлэлцүүлэгт оролцох боломжийг илүү тодорхой болгож, оролцогч талуудын эрх, үүргийг тодорхой зааснаар шийдвэр гаргах үйл явцын ил тод байдал нэмэгдэх юм.

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2026 оны 5 дугаар сарын 22-ны өдөр Улсын Их Хурал хэлэлцэн баталлаа.

Эдийн засгийн өсөлт, хөрөнгө оруулалтын орчин, байгаль орчныг хамгаалах бодлогын оглолцолд оршдог чухал хууль болох Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хүрээнд байгаль орчны үнэлгээний тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгож, төрийн үйлчилгээний үр ашгийг нэмэгдүүлэх, бизнес эрхлэгчдэд учирдаг хүндрэл бэрхшээлийг бууруулах томоохон алхам боллоо.

В Алдарт эхийн одон авахад "бага хүүхэд нь төрөөд, төрсний гэрчилгээ л авсан бол болзол хангасанд тооцдог боллоо"

“Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Болдын Уянга миний бие, Х.Баасанжаргал, Б.Баярбаатар, С.Эрдэнэбат, С.Эрдэнэболд нар хамтран санаачилж, батлуулсан.

“Алдарт эх”-ийн одонгийн шалгуурт өөрчлөлт оруулж, олон мянган эхийн эрхийг сэргээх боломж бүрдлээ. Өмнө нь мөрдөгдөж байсан зохицуулалтаар эхийн төрүүлсэн хүүхэд нэг нас хүрээгүй тохиолдолд “Алдарт эх” одонгоор шагнуулах болзол шаардлагыг хангадаггүй байсан. Үүний улмаас олон хүүхэд төрүүлсэн хэдий ч хүүхдээ 1 нас хүрэхээс нь өмнө алдсан эхчүүд төрийн энэхүү хүндэтгэл, урамшууллаас гадуур үлдэж ирсэн юм.

“Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай” хуулийн зохицуулалтаар урамшуулал авах болзолд “бага хүүхэд нь 1 нас хүрсэн байх”, “нас барсан хүүхэд нь 1 ба түүнээс дээш настай байсан байх” зэрэг нөхцөл тавигдаж байгаа нь хүний эрхийн зөрчил үүсгэж, хүүхдийг насаар нь ялгаварлах гадуурхах нөхцөл бүрдүүлснийг засах шаардлагатай гэж үзэн, урамшуулал олгох болзлыг хасах буюу хөнгөлөхөөр тусгасан. Тодруулбал, урамшуулал авахад тавигддаг “бага хүүхэд нь 1 нас хүрсэн байх”, “нас барсан хүүхэд 1 ба түүнээс дээш настай байх” зэрэг болзлуудыг хассан.

Хуулийн өөрчлөлтөөр хүүхдээ алдсан эхчүүдийг ялгаварлан үзэхгүйгээр олон хүүхэд тээж төрүүлсэн хөдөлмөр, гэр бүлдээ оруулсан хувь нэмрийг нь бодитой үнэлэх эрх зүйн боломжийг бүрдүүлсэн. Энэ нь зөвхөн одон, урамшууллын асуудал биш бөгөөд эх хүний хөдөлмөр, үнэ цэнийг төрөөс хүлээн зөвшөөрч буй чухал илэрхийлэл юм.

Хууль санаачлагчдын зүгээс энэхүү өөрчлөлт хэрэгжсэнээр улсын хэмжээнд 20 гаруй мянган эх “Алдарт эх”-ийн одонд хамрагдах боломжтой болно гэж тооцоолсон. Ингэснээр олон жил шийдлээ хүлээсэн асуудал бодитойгоор шийдвэрлэгдэх

нөхцөл бүрдэж байгаа юм.

Монгол Улсад хүн амын өсөлт, гэр бүлийн хөгжлийг дэмжих бодлого төрийн тэргүүлэх чиглэлийн нэг хэвээр байгаа. Энэ хүрээнд эхчүүдийн хөдөлмөрийг үнэлэх, нийгмийн хамгааллыг нь сайжруулах, гэр бүлийн үнэ цэнийг бэхжүүлэх зорилготой эрх зүйн шинэчлэлүүд шат дараатай хэрэгжиж байна.

Ийнхүү батлагдсан хуулийн өөрчлөлт нь олон хүүхэд төрүүлсэн эхчүүдийн хөдөлмөрийг илүү шударгаар үнэлэх, нийгмийн хамгааллын хүртээмжийг нэмэгдүүлэх, гэр бүл төвтэй хөгжлийн бодлогыг дэмжихэд чиглэсэн ач холбогдолтой шийдвэр боллоо. Энэ нь эхчүүдийн нийгэмд оруулж буй үнэт хувь нэмрийг төрөөс бодитоор үнэлж буй томоохон алхам хэмээн үзэж байна.

Г Монгол Улсын хэмжээнд өөр хэл дээр батлагдсан газар зүйн нэрийг монгол хэл рүү хөрвүүлэв

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 3 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэхийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2026 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн, Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр тус Байнгын хороонд шилжүүлсэн.

Байнгын хороо “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг Байнгын хорооны 2026 оны 01 тоот тогтоолоор байгуулсан бөгөөд Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянга миний бие, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай, Б.Бейсен, М.Ганхүлэг, Ж.Чинбүрэн, А.Ундраа нар ажиллалаа.

Энэ хугацаанд Хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс Баян-Өлгий, Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт хамаарах өөр хэл дээр батлагдсан газар зүйн нэрийн жагсаалтыг шинээр батлах, өөрчлөхтэй холбогдуулан газар зүйн нэрийн монгол кирилл үсгийн латин хөрвүүлгийн стандарт, зарим газар зүйн нэрийн монгол хэлний дүрмийн алдаатай эсэх талаарх лавлагаа, мэдээллийг авч ажиллалаа.

Мөн ажлын хэсгийн ахлагчаас Баян-Өлгий аймагт хамаарах зарим газар зүйн нэрийн талаар Монголын Тувачуудын нийгэмлэгээс ирүүлсэн саналтай холбогдуулан тус нийгэмлэгийн төлөөлөлтэй уулзаж, санал солилцон холбогдох тайлбар, мэдээллийг өгсөн болно.

-Энэ тогтоолоор баталсан газар зүйн нэрийг геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэх, Монгол Улсын Их Хурлаас баталсан газар зүйн нэрийг батлагдсан стандартад нийцүүлэн латин үсэгт галиглан хэрэглэх, газар зүйн нэрийг судлах, сурталчлах, хамгаалах, мөрдүүлэх, газар зүйн нэрийг цахим системээр дамжуулан хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;


-Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт хамаарах газар зүйн нэрийн тодотголыг хийж, сумдын хилийн цэсийг албан ёсны газар зүйн нэрийн дагуу шинэчлэн, холбогдох шийдвэрийн төслийг боловсруулж 2027 оны Намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

-Төслийн нэр томьёог жигдлэх, Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн тогтоолын заалтын дугаарыг өөрчлөн, бүтэц найруулга, латин хөрвүүлгэд холбогдох хууль зүйн техникийн засварыг хийлээ.



Ажлын хэсгийн өргөтгөсөн бүрэлдэхүүн

Д Байгалийн аливаа нөөц ашиглалт ил тод ашиглагдах учиртай



Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт ”Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна” гэж, түс зүйлийн 2 дахь хэсэгт ”...Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй” гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт ”Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж түс түс заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан ”Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 3.6 дахь заалтын 1-д ”Газар, түүний нөөцийг зохистой, ур дүнтэй ашиглах, иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод газрын харилцааны орчин бүрдсэн байна” гэж, 4.2 дахь заалтын 1-д ”Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, боловсруулалтын түвшин нэмэгдсэн байна” гэж, 6.2 дахь заалтын 1 -д ”Биологийн олон янз байдлыг хамгаалах, тархац нутаг, амьдрах орчныг нь тэтгэж хомсдолоос сэргийлэх, ашигт зүйлийг үржүүлэх, тарималжуулах, Ойн агропарк байгуулах замаар ашиглалтын нөөц бүрдүүлнэ” гэж, мөн заалтын 2-т ”Хөрсний үржил шим, чийгийг хамгаалж, газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэн, эвдрэлд орсон, доройтсон газрыг нөхөн сэргээж, аж ахуйн эргэлтэд оруулна” гэж, мөн заалтын 4-т ”Байгаль орчны хяналт шинжилгээний сүлжээ, кадастр, мэдээллийн санг өргөжүүлж, шинэ үеийн техник, технологийн шинэчлэл хийнэ” гэж, 6.3 дахь заалтын 2-т ”Усны сан бүхий газрын хамгаалалтын бус, ус хангамжийн эх үүсвэрийн эруул ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулж, усны бохирдол, хомсдолыг бууруулна” гэж, мөн заалтын 4-т ”Хүн амыг баталгаат ундны усаар хангах, усны нөөцийн эрэл, хайгуул, зураглалын ажлыг эрчимжүүлж нөөц баялгийн мэдээллийн бааз суурийг өргөжүүлэх, төлөвлөлт, менежмент хийх нөхцөлийг бүрдүүлнэ” гэж, мөн түс тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан ”Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.1.5-д ”Ил тод байдал, хамтын ажиллагаанд тулгуурлан гадаадад хөрөнгө оруулалтыг татах, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлнэ” гэж, 4.2.11-д ”Уул уурхайн салбарыг байгальд хал багатай, хариуцлагатай эдийн засгийн салбар болгон хөгжүүлнэ.” гэж, 4.2.12-т ”Уул уурхайн томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулахдаа олон улсын стандарт, хэм хэмжээг чанд мөрдөнө” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан ”Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 4.1.6.5-д ”олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах” гэж, Монгол Улсын Их Хурльн 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан ”Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 130-д Монгол Улсад эдийн засаг, нийгмийн урт хугацааны тогтвортой хөгжилд эрдэс баялгийн салбарын үзүүлэх үр нөлөөг дээшлүүлэх, эрдэс баялгийн салбарын ил тод байдлын эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор “Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулах” гэж тус тус заасан байна.

Байгалийн баялаг олборлох үйлдвэрлэл нь Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 20-30 орчим хувийг дангаараа хангаж, эдийн засгийн өсөлтийн гол эх сурвалж болж ирсэн төдийгүй эдийн засгийн бусад салбарт томоохон нөлөө үзүүлдэг. Байгалийн баялгийг олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд түшиглэн, улсын эдийн засгийг бэхжүүлэх, нөгөө талаас уг салбарыг нээлттэй, ил тод, хариуцлагатай байлгаж, татварыг улсын төсөвт зохистой төвшинд төвлөрүүлэх, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор хяналт, дүн шинжилгээ болон тайлагнал зэргийг иж бүрэн, ур дүнтэй хэрэгжүүлэх шаардлага тулгамдаад байна.

Үргэлжлэл нь 6 дугаар нүүрт

The UTimes
ШИНЭЛЭГ. СОНИРХОЛТОЙ. ҮНЭН

Дэлгэрэнгүйг эндээс

Д Байгалийн аливаа нөөц ашиглалт ил тод ашиглагдах учиртай

Түрүүч нь 5 дугаар нүүрт

Байгалийн баялаг ашиглах үйл ажиллагаа нь зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, гэрээ, эрхийн хүрээнд явагддаг бөгөөд Олон улсын валютын сан, Эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжлийн байгууллага, Дэлхийн банк, Мөнгө угаахтай тэмцэх, санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага зэрэг олон улсын байгууллагууд байгалийн баялаг, ялангуяа ашигт малтмалын нөөц баялаг ихтэй улс орны олборлох үйлдвэрлэлийг эрсдэлтэйд тооцож, авлига, хээл хахууль, мөнгө угаах болон бусад санхүүгийн гэмт хэргийн эрсдэлийг өндөр гэж үздэг.

Байгалийн баялаг ашиглах үйл ажиллагаан дахь шударга бус өрсөлдөөн, давамгай байдлыг бууруулах нь нийгмийн давхаргын ялгааг арилгахад бодит хувь нэмэр болно гэж үздэг. Төрийн болон орон нутгийн өмчит компани, үйлдвэрийн газрын худалдан авалтаар дамжуулж авлига хээл хахуулийг бодит бус үнэ өртгөөр худалдан авалт хийж дамжуулах, улсад их хэмжээний хохирол учруулсан жишээ өнгөрсөн хугацаанд гарснаар Монгол Улс олборлох үйлдвэрлэлийн мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр дорвитой арга хэмжээ авах шаардлага бий болсныг харуулж байна.

Дэлхийн улс орнуудын олборлох салбар, байгалийн баялаг ашиглалтын ил тод байдлыг хангахад чиглэгдсэн зохицуулалт нь ихэвчлэн кодекс буюу суурь хуулийн шинжтэй, энэ нь эрчим хүч, ашигт малтмал, газрын тос, байгалийн хий болон газар, ус зэрэг байгалийн баялгийн цогц мэдээллийг агуулдаг. Түүнчлэн эдгээр салбарт үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдийн эрх, зөвшөөрөл, гэрээ, эцсийн өмчлөгч, эцсийн эзэмшигч болоод орлого, татвар төлөлт, орон нутгийн харилцаа, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр өгөөж, нөлөөллийн талаар маш нарийн чиг үүргийн зохицуулалттай, харилцан уялдааг хангасан, аливаа төлөвлөлтийн шийдвэрт сонирхол нь хөндөгдөж буй бүх талын оролцогчид чөлөөтэй оролцох нөхцөлийг бүрдүүлсэн байдаг.

Монгол Улс байгалийн баялаг ашиглалтын ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх ажлыг шат дараалалтай хэрэгжүүлж ирсэн бөгөөд олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, төр болон хувийн хэвшлийг хариуцлагажуулах зорилго бүхий, дэлхийн 52 улс орон нэгдэн орсон "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай санаачилга" /цаашид "ОҮИТБС" гэх/-д 2007 онд, Нээлттэй засаглалын түншлэлд 2013 онд тус тус нэгдэж, олборлох үйлдвэрлэлд мэдээллийн ил тод байдлыг ханган хэрэгжүүлэхээр олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө үүрэг амлалтыг авсан.

Монгол Улсын Засгийн газраас 2006 онд "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай санаачилгыг дэмжих тухай" тогтоолыг баталж, санаачилгыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийг төрийн болон төрийн бус байгууллага, компанийн төлөөлөлтэйгөөр байгуулан ажиллах болсноор манай улс албан ёсоор "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай" олон улсын санаачилгыг хэрэгжүүлж эхэлсэн. ОҮИТБС-д байнга шинэ дэвшилтэт өөрчлөлтүүд гарч байгаа боловч ОҮИТБС-ын хүрээнд авсан үүрэг амлалтаа Монгол Улс бүрэн хэрэгжүүлэхэд хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, журам, маягт батлах зэргээр хэрэгжилтэд баримталж ирсэн өнөөгийн эрх зүйн орчин хангалттүй байна.

Тиймээс бие даасан хууль боловсруулан, хамаарах салбарыг тодорхойлох, тэдгээрийн мэдээллийг бүрдүүлсэн мэдээллийн сан бий болгох, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг нарийвчлан хуульчлах шаардлагатай байна. Болдын Уянга миний бие санаачлан өргөн барихад бэлэн боллоо. Түүнчлэн тусгай зөвшөөрлийн тоо өсөн нэмэгдэж, байгалийн баялгийг ашиглах үйл ажиллагаа өргөжин тэлэхийн хэрээр хариуцлагын асуудлыг иргэд, олон нийтийн зүгээс улам хурцаар тавих нь нэгэнт тодорхой болжээ. Төр, аж ахуйн нэгж болон орон нутгийн иргэд хоорондын харилцан ойлголцлыг бий болгосноор байгалийн баялаг ашиглалтын үл ажиллагаанд хөрөнгө оруулахад үүсэх эрсдэлийг бууруулж, эдийн засагт жинтэй хувь нэмэр оруулах холбогдох салбарын хөгжил зогсонги байдалд хүрэхээс сэргийлэх боломж бүрдэхээр байна.

Хууль батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал Байгалийн баялаг ашиглалтын ил тод байдлын тухай хууль батлагдсанаар улсын төсвөөс нэмэлт санхүүжилт шаардагдахгүй ба эрх зүйн орчныг бүрдүүлснээр урт хугацаанд нийгэм, эдийн засагт дараах эерэг үр дүн гарна гэж үзэж байна. Үүнд:

1/Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын олон улсын дэвшилтэт хандлагад нийцсэн хамтын удирдлага, хамтын хяналтын тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц бий болно.

2/Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд үргүй зардал гаргахад хүргэж буй, мөн хууль бус төлбөр, хураамж өгч, авдаг зохисгүй хандлагыг бууруулах, цаашид гарахаас урьдчилан сэргийлэх хууль, эрх зүйн зохицуулалттай болно.

3/Байгалийн баялаг ашиглах үйл ажиллагаанд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн зохистой түншлэлийн хэлбэр бий болно.

4/Авлига, ашиг сонирхлын зөрчлийг бууруулах, таслан зогсоох нөхцөл бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

5/Тусгай зөвшөөрөл эзэмшигч, төр, олон нийтийн байгууллага хоорондын харилцаа, үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүд ил тод болж, олон нийтийн зүгээс хяналт тавих боломжтой болно.

6/Төрийн өмчит аж ахуйн нэгжийн зардал буурснаар ашигт үйл ажиллагаа нэмэгдэж улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого нэмэгдэнэ.

7/Төлсөн татвар, хураамжийн зарцуулалт, хуваарилалт ил тод болсноор баялгийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх сэдлийг үр дүнтэй болгож бэхжүүлнэ.

8/Хуулийн төсөл батлагдсанаар өнгөрсөн хугацаанд улс, орон нутгийн төсвийн тодорхой хувийг бүрдүүлж байгаа орлогын талаарх мэдээллийг нэгдсэн байдлаар ил тод болгож байгаа амжилтыг улам цааш бэхжүүлж, хамрах хүрээг тэлнэ.

9/Засгийн газар, компаниудын удирдах болон шийдвэр гаргах эрх бүхий ажилтнуудын хариуцлагатай байдлыг нэмэгдүүлж, салбарын оролцогчдыг тодорхой болгож, олон нийт үнэн зөв мэдээлэл авах боломжийг бүрдүүлнэ.

10/Хуулийн нэр томьёо тодорхой болж, олборлох үйлдвэрлэлийн нээлттэй байдал нэмэгдсэнээр хөрөнгө оруулалтын орчин сайжирна.

11/Байгалийн баялгийн засаглал, үр өгөөж нэмэгдсэнээр нийгэм, эдийн засгийн зангилаа асуудлыг шийдвэрлэх боломжтой болж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах нөхцөл бололцоотой болно.

12/Хариуцлагатай үүл үүрхайг хөгжүүлэх болон байгаль орчныг хамгаалах талаас томоохон эерэг нөлөө үзүүлнэ.

Е Хүүхдийн хөгжлийг сайн дэмжих нь ирээдүйгээ л бодож байгаа хэрэг



"Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай" анхдагч хуулийн төслийг УИХ-ын гишүүн М.Бадамсүрэн, Болдын Уянга миний бие, Ж.Алдаржавхлан, Ч.Анар, Ж.Батжаргал, Д.Батлут, Д.Ганмаа, М.Ганхүлэг, Х.Жангабыл, С.Замира, Б.Заяабал, С.Зулпхар, Ц.Идэрбат, Л.Мөнхбаясгалан, Б.Мөнхсоёл, Л.Соронзонболд, А.Ундраа, Д.Үүрийнтуяа, Б.Хэрлэн, Д.Энхтүвшин, С.Эрдэнэбат нар санаачлан боловсруулж, 2026 оны 5 дугаар сарын 5-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн.

5 бүлэг 20 зүйл бүхий тус хуулийн төслийг 2026 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцэх эсэхийг дэмжиж, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд хуваарилсан юм. Тус байнгын хорооны 2026 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн 07 дугаар тогтоолоор хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, УИХ-ын гишүүн Л.Энхнасангаар ахлуулсан. Н.Алтаншагай, О.Батнайрамдал, Х.Болормаа, Ц.Галбадрах, Т.Мөнхсайхан, Ц.Мөнхтуяа, М.Нарантуяа-Нара, М.Сарнай нарын УИХ-ын гишүүд ажиллаж байна.

Энэхүү хуулийн төсөл нь хүүхэд бүрийн хичээлээс гадуурх сургалтад тэгш хамрагдах эрхийг баталгаажуулах, авьяас чадвар, сонирхолд нь тулгуурлан өөрийгөө хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн чухал алхам болж байна.

Өнөөдрийн байдлаар хүүхдүүдийн хичээлээс гадуурх хөгжлийн үйл ажиллагаанд хамрагдах боломж нь оршин суугаа газар, гэр бүлийн эдийн засгийн байдлаас ихээхэн хамааралтай байсаар ирлээ. Хот суурин газарт амьдардаг хүүхдүүд олон төрлийн дугуйлан, клуб, хөтөлбөрт хамрагдах боломжтой байхад орон нутаг, тэр дундаа алслагдмал бүс нутагт амьдарч байгаа, мөн нийгмийн эмзэг бүлгийн хүүхдүүд энэ боломжоос хөндийрсөн байдалтай байгааг бид бүхэн мэднэ. Уг тэгш бус байдлыг арилгах, хүүхэд бүрт адил тэгш боломж олгох, ирээдүйн бие хүн болж төлөвшихөд нь төрөөс бодлогын болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр төрийн байгууллагуудын чиг үүрэг, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны зарчим, үүрэг хариуцлага, хяналтын тогтолцоотой холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор энэхүү хуулийн төслийг боловсруулсан юм.

Хуулийн төсөл батлагдсанаар дараах асуудлуудыг шийдвэрлэнэ гэж хууль санаачлагчид үзэж байгаа юм. Үүнд:

1. Хүүхэд бүр хичээлээс гадуур авьяас, чадвараа хөгжүүлэх боломжтой байх ёстой боловч орон нутагт тогтвортой, чанартай үйл ажиллагаа явуулах санхүүгийн болон зохион байгуулалтын механизм тодорхойгүй байсан. Тухайлбал, зарим сум, дүүргүүдэд хүүхдийн хөгжлийн үйл ажиллагаа зохион байгуулах мэргэшсэн багш, дасгалжуулагч, зохион байгуулагчийн хомсдол мэдэгдэхүйц байсан бөгөөд санхүүгийн дэмжлэг тогтмол бус байдлаар олгогдож байна.

2. Хүүхдийн хөгжлийн үйл ажиллагааг зохион байгуулдаг байгууллага, хувь хүмүүс нэгдсэн бүртгэл, хяналтгүйгээр ажиллаж байгаагаас сургалтын чанар, хүртээмжийн асуудал үүсэж байна. Тухайлбал, ямар байгууллага, хаана, ямар чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа талаарх мэдээлэл байхгүй, мэдээлэл бүртгэлийн нэгдсэн санд байхгүй.

3. Хөгжлийн бэрхшээлтэй болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүд хүүхдийн хөгжлийн үйл ажиллагаанд хамрагдах боломж нь хязгаарлагдмал бөгөөд энэ бүлгийн хүүхдүүдэд тусгайлан зориулсан хөтөлбөр, дэмжлэгийн тогтолцоо бүрдээгүй зэрэг асуудлуудыг шийдвэрлэхийн тулд хуулийн төсөлд хэд хэдэн чухал зохицуулалтыг тусгасан.

Хуулийн төсөл нь хүүхэд хөгжлүүлэх үйл ажиллагааны санхүүжилтийг улсын болон орон нутгийн төсвөөс жил бүр тогтмол олгохоор тусгаж өгсөн нь санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах суурь болох юм. Мөн нийслэл болон аймаг бүрт Хүүхдийн хөгжлийн төв байгуулж, шинжлэх ухаан, технологи, гадаад хэл, спорт, биеийн тамир, соёл урлаг, сэтгэл зүйн боловсрол, санхүүгийн боловсрол, нийгмийн оролцоо зэрэг 9 чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг бүрдүүллээ.

Цаашид хүүхэд бүр хаана амьдарч байгаагаас үл хамааран чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлж, авьяас чадвараа бүрэн дүүрэн хөгжүүлэх боломжтой болно. Тэгш боломж олгосноор хүүхдүүд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлж, өөртөө итгэлтэй, бүтээлч, авьяаслаг иргэд болж өсөн төлөвших суурь нь энэ хуулиар тавигдаж байна гэдэгт итгэлтэй байна. Хүүхэд бүр улсын маань ирээдүй, үндэстний хөгжлийн нөөц болдог тул энэ чиглэлд хөрөнгө оруулалт хийх нь зөвхөн хүмүүнлэгийн бус, хөгжлийн стратегийн ухаалаг алхам юм.

Судалгаа, туршлагаас харахад хүүхдийн хичээлээс гадуурх хөгжлийн үйл ажиллагаанд оролцох нь тэдний сургалтын амжилт, нийгмийн харилцааны чадвар, сэтгэл зүйн тэнцвэртэй байдалд эерэгээр нөлөөлдөг болох нь тогтоогдсон байдаг.

Хуулийн төсөл батлагдсаны дараа Боловсролын яам, Хүүхдийн эрхийн үндэсний төвийнхөн энэхүү хуулийг амилуулж, хуулийн зохицуулалт бүрийг амжилттай хэрэгжүүлэхийг хүсэж байна.

Эцэст нь Монгол хүүхэд бүр өөрийн мөрөөдлөө биелүүлэх боломжтой орчинд өсч хөгжих эрх зүйн орчинг бүрдүүлэх ажлыг хамтдаа дэмжицгээе гэж хэлмээр байна.

Ашигт малтмалын тухай хуулийн талаар

Монгол Улсын Засгийн газраас Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, 2026 оны 5 дугаар сарын 26-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн.

Хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын 2026 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 275 дугаар захирамжаар байгуулсан бөгөөд УИХ-ын гишүүн Б.Жавхлан ахалж, УИХ-ын гишүүн Д.Батбаяр, Р.Батболд, О.Батнайрамдал, Н.Наранбаатар, Ц.Туваан, А.Ундраа, Б.Мөнхсоёл, Д.Үүрийнтуяа, Р.Эрдэнэбүрэн болон Болдын Уянга миний бие ажиллаж байна.

Монгол Улсын эдийн засгийн өсөлт, экспортын орлого, төсвийн бүрдүүлэлтийн гол эх үүсвэр нь уул уурхайн салбар хэвээр байна. Гэвч өнөөдөр бид 2006 онд батлагдсан хуулийн хүрээнд ажиллаж байгаа, гэтэл дэлхийн уул уурхайн бүтээгдэхүүний зах зээл, технологи, хөрөнгө оруулалтын орчин эрс өөрчлөгдсөн. Тиймээс Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, салбарын эрх зүйн орчныг шинэ шатанд гаргах шаардлага бий болсон гэж ойлгож болно.

Энэ хуулийн төслийг зарим хүмүүс зөвхөн лицензтэй холбоотой асуудал мэтээр ойлгож байгаа. Үнэн хэрэгтээ энэ нь геологийн судалгаа, баяжуулалт, нөхөн сэргээлт, орон нутгийн оролцоо, хариуцлагатай уул уурхай гэсэн цогц шинэчлэлийн тухай асуудал юм.


Миний бие Ажлын хэсэгт ажиллаж буй гишүүнийхээ хувьд, УИХ-ын гишүүн болохынхоо өмнө Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд /хуучин нэрээр/ ажиллаж байхдаа энэ хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсэгт ажиллаж байсны хувьд, мөн энэ салбарын мэргэжилтний хувьд Ашигт малтмалын тухай хуульд оруулж буй нэмэлт, өөрчлөлтийн гол үзэл санааг тоймлон тайлбарлая.

1. Монгол орны ихэнх нутаг дэвсгэрт нарийвчилсан геологийн судалгаа хангалтгүй хэвээр байна. Улсын төсвийн боломж хязгаарлагдмал учраас бид зөвхөн улсын төсвийн хөрөнгөөр бүх судалгааг хийх боломжгүй. Тиймээс хувийн хэвшлийн хөрөнгөөр геологийн суурь судалгаа, эрлийн ажил хийх шинэ тогтолцоог хуулийн төсөлд тусгасан. Аж ахуйн нэгж өөрийн хөрөнгөөр эрсдэлээ үүрч судалгаа хийж, үр дүн гарсан тохиолдолд тодорхой шалгуурын дагуу хайгуулын зөвшөөрөл хүсэх боломжтой болох юм. Ингэснээр Монгол Улс шинэ ордын нөөцөө нэмэгдүүлж, геологийн мэдээллийн сангаа өргөжүүлнэ.

2. Өнөөдөр Монгол Улс их хэмжээний түүхий эд экспортолж байгаа ч нэмүү өртгийн ихэнхийг гадаад улс орнууд хүртэж байна. Тиймээс хуулийн төсөлд баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг бие даан зохицуулах шинэ бүлгийг тусгасан. Энэ нь уул уурхайн бүтээгдэхүүнээ зөвхөн олборлоод гаргах бус, дотооддоо баяжуулж, боловсруулж, илүү өндөр үнээр борлуулах бодлогыг дэмжих зорилготой. Уул уурхайн баялаг зөвхөн газрын хэвлийд байхдаа биш, боловсруулалт хийгдэж байж бодит эдийн засгийн үнэ цэн бүтээдэг.

3. Дэлхий нийт литий, газрын ховор элемент, кобальт зэрэг өндөр технологийн үйлдвэрлэлд шаардлагатай ашигт малтмалын төлөв өрсөлдөж байна. Цаашдаа эрчим хүчний шилжилт, цахилгаан автомашин, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл эрчимжихийн хэрээр эдгээр ашигт малтмалын үнэ цэн улам өсөх төлөвтэй байгаа. Тиймээс бид “чухал ашигт малтмал” гэсэн ойлголтыг хуульд шинээр оруулж, төрөөс бодлого, стратеги, замын зураглалтай ажиллах эрх зүйн үндсийг бүрдүүлж байна. Манай улс зөв цагтаа зөв бодлого хэрэгжүүлж чадвал дэлхийн нийлүүлэлтийн сүлжээнд чухал байр суурь эзлэх боломж бий.

4. Уул уурхайн салбарт иргэдийн хамгийн их шүүмжилдэг асуудлын нэг нь эвдэрсэн газар, орхигдсон уурхай байдаг. Үүнийг цэгцлэхээр уурхай ашиглаж байх хугацаанд нь хаалт, нөхөн сэргээлтийн хөрөнгийг үе шаттайгаар бүрдүүлэх зохицуулалтыг тусгасан. Өөрөөр хэлбэл уурхай хаагдсаны дараа мөнгө хайдаг биш, ашиглалтын хугацаанд нь санхүүгийн баталгааг бүрэн бүрдүүлдэг болно. Энэ бол байгаль орчны өмнө хүлээх хариуцлагыг илүү бодитой болгож байгаа шийдэл юм.


Чуулганы нэгдсэн хуралдаан. Б.Заяабал, Г.Лувсанжамц гишүүдийн хамт

5. Уул уурхайн үйл ажиллагаа явагдаж байгаа орон нутгийн иргэд мэдээлэлтэй байх эрхтэй. Тиймээс тусгай зөвшөөрөл эзэмшигчид үйл ажиллагааныхаа талаар тогтмол мэдээлж, тайлагнадаг болох, иргэд болон төрийн бус байгууллагууд хяналт тавих, санал өгөх эрхээ хэрэгжүүлэх боломжийг илүү тодорхой болгохыг зорьж байна.

6. Мөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос орон нутагт очих үр өгөөжийг нэмэгдүүлэх зохицуулалтуудыг тусгагдсан.

7. Бичил уурхай эрхлэгчид ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлдөг болно, мөн үйл ажиллагааныхаа тайланг жилд 1 удаа тухайн сум, орон нутгийн Засаг даргад тайлагнадаг болно.

Энэ хуулийн төсөл хөрөнгө оруулалт татахын төлөө байгаль орчноо золиослох тухай биш. Эсвэл байгаль хамгаалах нэрээр хөгжлөө зогсоох тухай ч биш. Бидний зорилго бол уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт, байгаль орчны хамгаалал, орон нутгийн эрх ашиг гэсэн гурван үндсэн ашиг сонирхлын тэнцвэрийг бий болгох явдал гэж ойлгож болно. Монгол Улс баялгаа ашиглах ёстой. Гэхдээ хариуцлагатайгаар ашиглах ёстой. Ирээдүй хойч үедээ өр үлдээхгүйгээр, харин боломж үлдээх ёстой. Ашигт малтмалын тухай хуулийн төсөл яг энэ зорилгод чиглэж байгаа юм.

Электрон тамхинд татвар оногдуулдаг болж, үнэр амтыг арилгана


Чуулганы нэгдсэн хуралдаан. Монгол Ардын Намын гишүүдийн жигүүр

2025 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, А.Ариунзаяа, Ө.Шижир, Б.Баярбаатар, М.Мандхай, С.Эрдэнэболд, Б.Мөнхсоёл, С.Замира, Д.Рэгдэл, Д.Ганмаа, Ч.Анар, Г.Лувсанжамц, Д.Энхтүвшин, Дав.Цогтбаатар, Ч.Номин, Н.Батсүмбэрэл, Р.Батболд, Б.Бат-Эрдэнэ, Ж.Золжаргал, М.Ганхүлэг, Л.Соронзонболд, С.Эрдэнэбат болон Болдын Уянга миний бие Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн мэдүүлсэн. Энэ хуулийн төслийг Улсын Их Хурлын 72 гишүүн санаачлан боловсруулсан юм.

Хуулийн төслийн гол зорилго нь иргэдийн дунд хэрэглээ нь эрс нэмэгдэж байгаа бүх төрлийн тамхидалтыг бууруулах, ялангуяа өсвөр насны хүүхэд, залуучуудын дунд түгээмэл хэрэглэж байгаа төрөл бүрийн электрон тамхийг янжуур тамхитай ижил зохицуулалттай болгож, ирээдүй үеэ хорт зуршлаас сэргийлж, эрүүл мэндийг хамгаалахад чиглэж байгаа юм.

Манай улсад Тамхины хяналтын хууль анх 1993 онд батлагдсан бөгөөд 2005 оноос шинэчлэгдэж, нийт найман удаа нэмэлт, өөрчлөлт орсон. Гэвч Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээгээр хуулийн хэрэгжилт хангалтгүй, хяналт сул, хууль бус худалдаа ихэссэн, хяналтын байгууллагуудын уялдаа холбоо муу байгаагаас өсвөр үе, залуучуудын дунд тамхины хэрэглээ өсөж, эрүүл мэнд, сэтгэл зүйд сөргөөр нөлөөлж байна. Монгол Улсад тамхинаас шалтгаалсан нас баралт нийт нас баралтын 17 хувийг эзэлж, жил бүр ойролцоогоор 4,300 хүн тамхины хэрэглээтэй холбоотойгоор нас барж байгаа ба тамхины хэрэглээнээс шалтгаалсан эдийн засгийн алдагдал жил бүр 801 тэрбум төгрөгт хүрч, дотоодын нийт бүтээгдэхүүний 2.1 хувийг эзэлж байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас (ДЭМБ) 2021 онд гаргасан “Электрон тамхи ба эрүүл мэнд” тайланд эдгээр бүтээгдэхүүнүүд нь амьсгалын замын үрэвсэл үүсгэх, зүрх судасны системд сөргөөр нөлөөлөх, никотинд донтох эрсдэл өндөртэй болохыг онцолсон. Мөн энэхүү тайланд “электрон тамхи нь тамхинаас гарах хэрэгсэл биш бөгөөд өсвөр үеийнхэн, залууст донтох шинэ зам болж байгааг анхаарах шаардлагатай” хэмээн юм.

Иймд төрөөс тамхидалтын эсрэг дорвитой арга хэмжээ авах зайлшгүй шаардлага үүссэн тул Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг ийнхүү боловсруулсан.

The UTimes
ШИНЭЛЭГ. СОНИРХОЛТОЙ. ҮНЭН

Дэлгэрэнгүй эндээс

Уншуушtай

А Хог хаягдлаа зөв ашиглах боломжтой

Хог хаягдал дахин боловсруулах, сэргээн ашиглах үйлдвэрлэлийг хөгжүүлснээр хог булшлах асуудлаас нөөц болгон ашиглах тогтолцоонд шилжих суурийг тавихаар боловсруулсан "Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай" УИХ-ын тогтоолын төслийг 2026 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж, хуралдаанд оролцсон нийт 95 гишүүдээс 61 гишүүн дэмжиж, 64.2 хувийн саналаар эцэслэн батлагдсан юм.

Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг УИХ-ын гишүүн Б.Мөнхсоёл ахалж, гишүүдээр Болдын Уянга миний бие, Н.Алтаншагай, С.Ганбаатар, Ж.Золжаргал, А.Ундраа, С.Одонтуяа, Т.Мөнхсайхан нар ажилласан.

Ажлын хэсэг салбарын яам, орон нутгийн байгууллагууд, төрийн болон төрийн бус байгууллага, дахин боловсруулах үйлдвэрийн төлөөллүүдтэй хамтран таван удаагийн хуралдаан, хоёр үүлзалт, дөрвөн хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт 43 байгууллага, 400 гаруй иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцож, нийт 175 санал ирүүлснийг нэгтгэн боловсруулсан.

Ажлын хэсгийн дүгнэлтээр Монгол Улсын хог хаягдлын менежмент, санхүүжилтийн тогтолцоо нь зөвхөн цуглуулах, тээвэрлэх, булшлах үйл ажиллагаанд төвлөрч, санхүүжилт хангалтгүй, хүний нөөцийн тогтворгүй байдал, хариуцлагын сул механизм нь салбарын хөгжлийг сааруулж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг нэмэгдүүлж байгааг онцолсон юм.

Түүнчлэн, хог хаягдлын санхүүжилтийн тогтолцоог шинэчилж, "үүсгэсэн хэмжээгээр төлөх" зарчимд суурилсан төлбөрийн механизмыг нэвтрүүлэх, үйлчилгээний чанар, үр ашгийг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай гэж үзсэн байна.

Мөн орон нутгийн төвлөрсөн


2026.04.13. Улаанчулуутын хогийн цэг

хогийн цэгүүдийн менежмент, хэмжилт, бүртгэлийн тогтолцоог сайжруулж, орчин үеийн техник, мэдээллийн нэгдсэн системээр хангах, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн иж бүрэн үнэлгээнд тулгуурлан шинэчлэх, нөхөн сэргээх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх шаардлагатайг тэмдэглэсэн.

Уг тогтоолд хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, үйлдвэрлэгчдийн хариуцлагыг сайжруулах талаар эрх зүйн шинэчлэлийг тусгасан. Хамгийн эхэнд авах арга хэмжээ нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийг сайжруулах хэрэгтэй. Тэр мэдээж хугацаа орох тул одоо байгаа хууль эрх зүйн орчны хүрээнд хог үүсгэж буй этгээд хариуцлагаа бүрэн хүлээдэг байх дээр хамтран ажиллах хэрэгтэй байна.

Б "Өмнөговь U-Марафон 2026" боловсролын аяныг 2 дахь жилдээ амжилттай өрнүүллээ

Өмнөговь аймгийн сурагч, оюутан залуусын мэдлэг, бүтээлч сэтгэлгээ, нийгмийн оролцоог нэмэгдүүлэх зорилготой "Өмнөговь U-Марафон 2026" боловсролын аян"-ыг бид 2 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. Аяныг Боловсролын яам болон холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, ирээдүйн инженер, манлайлагч залуусыг дэмжихэд чиглэсэн олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлсэндээ баяртай байгаа.

Аяны хүрээнд Өмнөговь аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 10-12 дугаар ангийн сурагчид, ШУТИС-ийн харьяа Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургууль хамрагдсан бөгөөд нийгмийн төсөл, эссе бичлэгийн уралдаан, сургалт, цахим контентын тэмцээн зэрэг олон арга хэмжээ зохион байгууллаа. Эссе бичих гэдэг бол тусгайлсан сургалт шаардах чадвар гэж үзэн мэргэжлийн багшаар сурагчдаа бэлтгэсэн. Цахим контент бэлдэх, илтгэх ур чадвар мөн адил сурдаг чадвар тул холбогдох сургалтыг тэмцээний эхэнд санал болгосон. Сургалтад идэвхтэй хамрагдаж, тэмцээнээ сайн дуусгасан залуусаараа бахархсан. Ирэх жил эргээд уулзацгаая.


Даланзадгад сумын оролцогчдыг идэвхжүүлэх U day арга хэмжээ

ЗАЛУУ ҮЕИЙН БҮТЭЭЛЧ САНААЧИЛГЫГ ДЭМЖИВ

"Өмнөговь U-Марафон 2026" боловсролын аяны онцлох арга хэмжээний нэг болох нийгмийн төслийн уралдаан нь тогтвортой хөгжлийн зорилтуудыг сурталчлах, өсвөр үеийнхний багаар ажиллах чадвар, асуудал шийдвэрлэх ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн юм. Оролцогчид жендэрийн эрх тэгш байдал, хариуцлагатай хэрэглээ, уур амьсгалын өөрчлөлт зэрэг нийгмийн чухал асуудлуудаар төсөл боловсруулж, бодитоор хэрэгжүүлэн үзүүлсэн нь онцлог байлаа.

Уралдаанд оролцсон багууд хог хаягдлын менежмент, сэргээгдэх эрчим хүч, ус цэвэршүүлэх технологи, ухаалаг нийтийн тээвэр зэрэг олон шинэлэг санааг дэвшүүлэн хэрэгжүүлсэн байсан.

ШИЛДЭГ БАГУУД ШАЛГАРЛАА

Нийгмийн төслийн уралдааны Даланзадгад бүсийн тэргүүн байрыг "NovaX" баг, хоёрдугаар байрыг "Humunity" баг, гуравдугаар байрыг "ST Group" баг эзэлсэн бол Цогтцэций сумаас "Idea2Impact" баг, Ханбогдоос "Hydro Hub" баг, Гурвантэсээс "Twoninety" багууд тус тус тэргүүлсэн.

Харин эссе бичлэгийн төрөлд сурагчид байгаль орчин, хариуцлагатай хэрэглээ, эрчим хүчний хэмнэлт, уур амьсгалын өөрчлөлт зэрэг сэдвээр үзэл бодол, шийдлээ илэрхийлж өрсөлдсөнөөс Даланзадгад сумаас А.Цэцэнбилэг, Гурвантэс сумаас Г.Анужин, Ханбогд сумаас Б.Мөнх-Эгшиглэн, Цогтцэций сумаас Э.Азбилэг нар тэргүүн байрт шалгарсан.

ЦАХИМ ХЭРЭГЛЭЭГ ЗӨВ ТӨЛӨВШҮҮЛЭХЭД ХУВЬ НЭМЭР ОРУУЛАВ

Энэ жилийн аяны нэгэн онцлог нь сурагч, залуусын цахим хэрэглээг зөв төлөвшүүлэх, нийгэмд эерэг мэдээлэл түгээхэд чиглэсэн үйл ажиллагаа байв. Оролцогчид өөрсдийн төслийн талаар цахим контент бүтээж, олон нийтэд хүргэсэн нь тэдний бүтээлч байдал, манлайлах ур чадварыг хөгжүүлэхэд түлхэц болсон гэж үзэж байна. Тус аянд нийт 150 гаруй хүүхэд, залуус хамрагдсан бөгөөд урлаг, соёлын төлөөлөл болсон уран бүтээлчид, контент бүтээгчид, менторууд оролцож, сурагч залууст урам зориг өгсөн юм.

ИРЭЭДҮЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

“Өмнөговь U-Марафон” боловсролын аянь залуусын мэдлэг боловсролыг дэмжихээс гадна нийгмийн сайн сайхны төлөөх бодит санаачилга, төслүүдийг бий болгосон үр дүнтэй арга хэмжээ болж чадлаа.

Бидний зүгээс уг аяныг дараагийн жилүүдэд илүү өргөн хүрээнд зохион байгуулахаар төлөвлөж байгаа бөгөөд энэ нь Өмнийн цэнхэр говийн ирээдүй хойч үеийнхний оюуны хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулна хэмээн итгэж байна.

В Морьтон Монгол бүсгүйчүүд сайхан наадлаа

2026 оны 6 дугаар сарын 7-нд Монгол түмний хийморь сэргээсэн, морьтон ардын минь бахархал болсон адуучин бүсгүйчүүдийнхээ дунд дурсамж бүтээсэн нэгэн сайхан өдрийг өнгөрүүлэв. Өмнөговь аймаг бол байгалийн гайхамшигт тогтоц, тэмээн сүрэг, хурдан хүлэг, эрэмгий адуучид, малч ухаанаараа алдартай нутаг гэдгийг бүрэн утгаар нь мэдрэв.

Миний ээж Цогтцэций сумын хөдөлмөрч, дайчин эмэгтэй бий. Өвөө, эмээ, нагацууд маань энэ сайхан нутагт хэдэн үеэрээ амьдарч ирсэн учраас Өмнийн цэнхэр говь минь сэтгэлд дотно дурсамж шингэсэн, бахархал болсон онцгой нутаг. Тиймдээ ч Говийн гоёл адуучдын холбооныхонтойгоо хамтран ажиллах болсондоо их баярласан.

Говийн догшин угалз, төөнөх халуун нар, хатуу хөтүү бүхнийг сөрөн зогсож, говь шарга адуугаа маллан өсгөхийн зэрэгцээ өв соёл, уламжлалт ахуйгаа нандигнан тээж яваа адуучин бүсгүйчүүдийнхээ хөдөлмөр, тэсвэр хатуужил, гоо үзэмжийг алдаршуулан нэгэн зураг номыг манай ажлын албанаас бүтээсэн. Богино зайн уралдаан нь хурдтай байсан. Саад сүлжих эрдэм нь гарамгай байсан. Буухиа уралдааны хамтрал нь нягт, ташуур шүүрэх авхаалж нь ихэд гарамгай байсан. Сүр жавхаа, гоо үзэсгэлэнгээрээ наадмын талбайг чимж, эрдэмт хүлгийнхээ нуруун дээр омог бардам заларсан эрэмгий бүсгүйчүүдтэйгээ зэрэгцэн баярын жагсаалд алхсан дурсамж маань үүрд хадгалагдан үлдэх болно оо.

Адуучин бүсгүйчүүдийн ур чадвар, авхаалж самбааг сорин таниулахаас гадна, нүүдэлчин ахуй, өв уламжлалаа олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хойч үедээ өвлүүлэн үлдээх эрхэм зорилготой энэхүү арга хэмжээ жилээс жилд өргөжин тэлж, үнэ цэн нь улам бүр өснө гэдэгт итгэлтэй байна.

Үндэстний дархлааг бэхжүүлэгч “Говийн гоёл” адуучдын холбооны-хондоо талархал илэрхийлж, амжилт хүсье.

Арга хэмжээнд Өмнөговь аймгийн Ханхонгор, Цогт-Овоо, Цогтцэций, Хүрмэн, Баян-Овоо, Номгон, Сэврэй, Булган, Ноён, Баяндалай, Даланзадгад гэсэн 12 сумын морьтон бүсгүйчүүд оролцсон. Нийт 6 төрлөөр өрсөлдсөнөөс шагналт байранд:


Ханхонгор сумын ахмад малчин Н.Аюуш, Засаг дарга Т.Наранжаргал, ИТХ-ын дарга А.Баяр-Эрдэнэ нарын хамт

Буухиа: Тэргүүн байр - Даланзадгад Ш.Бадамханд, Г.Түвшинжаргал, н.Саруултуул, Дэд байр - Ханхонгор Хондот баг Э.Оргилмаа, Т.Нандинбилэг, Ц.Даваацэрэн, Гутгаар байр - Ханхонгор Мандах баг Ө.Амаржаргал, О.Болормаа М.Болор- Эрдэнэ, Тусгай байр - Баяндалай сум Ө.Хатантуул, Б.Оюундарь, Ө.Мөнхзул, Тусгай байр - Ханхонгор Мандах 2 баг Х.Оюун, Н.Ургамалцэцэг, Т.Батболд нар шалгарсан.

Ганган морьтон: Тэргүүн байр- Цогтцэций Т.Баярмаа, Дэд байр - Цогтцэций А.Буян-Өлзий, Гутгаар байр - Ханхонгор Б.Тогтохорол, Тусгай байр - Ханхонгор Б.Хулан, Тусгай байр- Ханхонгор Б.Алтанцэцэг нар шалгарсан.

Богино зайн уралдаан: Түрүү- Ханхонгор Б.Ариунцэцэг - Саарал морь, Аман хүзүү - Ханхонгор Ж.Эрдэнэчимэг- Алаг морь, Айргийн 3-т - Ханхонгор Б.Алтанцэцэг- Хээр морь, Айргийн 4-т - Цогтцэций О.Нэргүй- бор морь, Айргийн 5-д- Ханхонгор С.Гэрэлцэцэг - Шарга халзан морь нар шалгарсан.

Ташуур шүүрээ: Тэргүүн байр - Ханхонгор Ө.Амаржаргал, Дэд байр - Ханхонгор М.Болор-Эрдэнэ, Гутгаар байр- Баяндалай Ө.Хатантуул, Тусгай байр - Ж.Сайхантуяа, Тусгай байр - Хүрмэн Д.Намуунцэцэг, Тусгай байр - Номгон С.Нэргүй нар шалгарсан. Та бүхэндээ халуун баяр хүргэе.

Мөн арга хэмжээний үеэр салбарын болон төрийн одон медалиар шагнагдсан алдартнууд бий. Хөдөө аж ахуйн тэргүүний ажилтнаар С.Оюунсүрэн, Ц.Амарбаясгалан, Б.Бат-Эрдэнэ, Х.Бурмаа, Ш.Бат-Өлзий, П.Оюунханд, П.Болормаа, Д.Түвшин, П.Хатанбаатар, Ц.Эрдэнэ-цэцэг, Т.Сугиабаатар, Г.Баянтөр, Ц.Батсайхан шагнагдлаа. Боловсролын тэргүүний ажилтнаар Г.Үүрийнтуяа, Алтангадас одонгоор Намжилдорж Аюуш, Гүр Чулуунцэцэг нар шагнагдлаа.

Та бүхэндээ амьдралын хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Г Дурсамжийн дэвтэр арга хэмжээ


ШУТИС Коосэн-ын 12 дугаар ангийн хамт олон

“Дурсамжийн дэвтэр” гэдэг хүүхдийн цэцэрлэгээс эхлээд сурагч нас хүртэлх өсөлт хөгжил, найз нөхөд, сургууль, аялал зугаалга болон хамгийн сайхан мөчүүдийг тэмдэглэн дурсамж үлдээх зориулалттай зүйл билээ. Мөн хүүхэд өөрийн мөрөөдөл, ирээдүйн төсөөлөл, дуртай зүйлсээ зураг, бичвэрээр илэрхийлж, амьдралынхаа нандин дурсамжийг бүтээх боломжийг олгодог. Иймийн учир УИХ-ын гишүүн Болдын Уянга миний бие Өмнөговь аймгийн хэмжээнд 12 дугаар анги төгсөж буй сурагчдадаа он жил өнгөрөхөд хүүхэд бага насныхаа аз жаргалтай мөчүүдийг эргэн санах үнэ цэнтэй дурсгал болон хадгалагдан үлдээх зорилгоор “Дурсамжийн дэвтэр”-ийг гардуулсан юм. Үүнд:

Даланзадгад сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 12а, 12б анги, 6 дугаар сургуулийн 12а, 12б анги, Гурвантэс сумын ерөнхий боловсролын сургуулийн 12а, 12б анги, мөн сумын 2 дугаар сургуулийн 12а, 12б анги, 5 дугаар сургуулийн 12а, 12б анги, 7 дугаар сургуулийн 12а, 12б анги, Баяндалай сумын ерөнхий боловсролын сургуулийн 12а ангийн хамт олонд дурсамжийн дэвтэр хадгалуулан, хамгийн гоё бөглөж, хамт олон, найз нөхөддөө насан туршийнх нь дурсамж үлдээж буй хамт олныг шалгаруулна хэмээн зарласан билээ.

Дурсамжийн дэвтрээ аль анги хамгийн сайн бөгөөд гоё бөглөж, тэмдэглэл хөтөлсөн бэ гэдэг дээр уралдаан зарлаж, байр эзлүүлсэн. Уралдаанд Ханбогд сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн Ж.Жавхлан багштай 12а ангийн сурагчид шалгарсан. Мундаг байсан.

Түс хамт олныг ангийн багшийн хамтаар Сэлэнгэ аймгийн Мандал суманд байрлах Шонхор Хүүхдийн зусланд амрах эрхийн бичгээр шагнасан юм. Нэгэн ангид 12 жил


Ханбогд сумын 2р сургууль 12а анги

хамтдаа суралцсан, ижилдэн дасаж олон хаврыг үдсэн, даль жигүүрээ дэлгэн зүг зүг нисэж, оюутан хэмээх эрхэм нэрийг өвөрлөн мордох гэж буй дүү нараа байгалийн үзэсгэлэнт газарт хамтдаа амарч, мартагдашгүй сайхан дурсамж сэтгэлдээ тээн үлдэнэ хэмээн Уянга эгч нь итгэж байна.

Инээд хөөр, гуниг харуслаа
хуваалцсан өдрүүд
Зүрхний гүнд мөнхрөн дурсамж
болон үлдэнэ.
Нэг ангийн нөхөд мөрөөдлөө тээгээд
Нэгэн тэнгэрийн дор салаа замаар
алхацгаана.
Цаг хугацаа та нарыг алсад хүргэсэн ч
Сэтгэлийн холбоо хэзээ ч тасрахгүй.
Сургуулийн босгоор хамтдаа
алхсан найзууд
Сайхан ирээдүй рүү итгэл
дүүрэн тэмүүлнэ.
Амжилтын оргил өвөд
зоригтой алхаж,
Аз жаргалын жимээр гэрэл
түгээн яваарай.
Ангийн нөхөддөө сайн сайхныг ерөөж,
Алтан дурсамжаа нандигнан
хадгалаарай.

The UTimes
ШИНЭЛЭГ. СОНИРХОЛТОЙ. ҮНЭН

Дэлгэрэнгүйг эндээс

Бодуушатай

А Asian Women Leadership программ Өмнөговь аймагт хэрэгжив

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг дэмжих чиглэлээр 2022-2031 онд хэрэгжүүлэх салбар дундын стратеги төлөвлөгөөг баталсан. Төлөвлөгөөний “Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо, манлайллыг нэмэгдүүлэх” зорилгыг хэрэгжүүлэх үүднээс 2026 оны 5 дугаар сарын 26-27-нд Өмнөговь аймагт “Ази, Номхон далайн бүс нутгийн эмэгтэйчүүдийн манлайлал, шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн тэгш бус байдлыг арилгах зорилгоор “Азийн эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөр” хэрэгжлээ. Хөтөлбөрт аймаг, сумын иргэдийн төлөөлөгч 25 бүсгүйчүүд хамрагдав.

Энэ үеэр эмэгтэйчүүддээ зориулан "Улстөрийн манлайлалд эмэгтэйчүүдийн оролцоо" сэдэвт илтгэл хэлэлцүүлсэн. Олон мундаг эмэгтэйчүүдтэй уулзаж, танилцсан сайхан хөтөлбөр боллоо. Та бүхэнтэйгээ олон жил хамтран ажиллах ерөөл дэвшүүлье.



Жендэрийн үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга А.Адилбиш, Жендэрийн үндэсний шинжээчдийн булгийн ахлагч Д.Сүхжаргалмаа нарын хамт

Б 2026 онд Улсын төсөвт тусгуулсан саналууд

1. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах санхүүжилтийг 2026 онд 2 дахин нэмэгдүүлсэн. Хамтран ажилласан С.Эрдэнэбат, Д.Рэгдэл, С.Зулпхар гишүүддээ талархал илэрхийлье.

Энэ хүрээнд 2026 оны 6 дугаар сарын 14-нд Өмнөговь аймгийн Цогтцэций суманд “Тоосжилтын улмаас үүсэж буй мэргэжлээс шалтгаалсан өвчний талаар тандан судалгаа хийж, хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ"-г Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвөөс зохион байгуулсан. Энэ хүрээнд тоосжилтод байнга өртөж буй 1000 албан хаагчийг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, үүшгины тоосжилтын шинжилгээ хийв. Цаашдаа энэ төрлийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах нөхцөл бүрдлээ. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлыг гол чигээ болгон шийдвэрлэхээр ажиллаж буй салбарын сайд Т.Аубакир танд баярлалаа. Мөн албан хаагчдаа идэвхтэй хамруулсан “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК болон “Энержи Ресурс” ХХК-ийн хамт олонд талархал илэрхийлье.



2026-06-13. Тоног төхөөрөмж гардуулах үйл ажиллагаа

2. Говийн бүсэд Хүүхэд хамгаалах, түр байршуулах байрнуудын тохижилт, тоног төхөөрөмж худалдан авахад зориулан хөрөнгө оруулалт суулгасан. Ингэснээр эрсдэлд орсон хүүхдийг хамгаалах бодит нөхцөл бүрдэнэ гэж үзсэн. Энэ хүрээнд:

ӨМНӨГОВЬ АЙМАГТ АЖИЛЛАЖ, ХҮҮХЭД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР БОДИТ АЛХМУУДЫГ ХИЙЛЭЭ

2026 оны 6 дугаар сарын 13-14-ний өдрүүдэд УИХ-ын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, УИХ-ын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар нарын хамт Өмнөговь аймагт ажиллав. Томилолтын хүрээнд хүүхэд хамгаалал, гэр бүл, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж, салбарын ажилтан албан хаагчид болон иргэдийн санал хүсэлтийг сонсон, тулгамдсан асуудлуудыг газар дээр нь хэлэлцлээ.

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БАЙГУУЛЛАГУУДАД 115 ШИРХЭГ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ГАРДУУЛЛАА

Говийн бүсийн хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан болон түр хамгаалах байрны ажилтнуудын нэгдсэн зөвлөгөөний үеэр Өмнөговь, Дорноговь, Дундговь, Говьсүмбэр аймгийн хүүхэд хамгаалын байгууллагуудад шаардлагатай 115 ширхэг тоног төхөөрөмжийг гардуулан өгсөн.

“Хүүхдийн төлөөх хөрөнгө оруулалт бол ирээдүйн төлөөх хамгийн үнэ цэнтэй хөрөнгө оруулалт” болохыг онцолж, хүүхдийн эрх, хамгааллыг бэхжүүлэх чиглэлээр тууштай ажиллахаа миний бие өөрийн биеэр илэрхийлсэн.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛТАЙ ТАНИЛЦАВ

Томилолтын үеэр Өмнөговь аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн газар болон “Энэрэл” хүний хөгжлийн төвийн үйл ажиллагаатай танилцлаа. Эдгээр төв 2026 оны эхний хагас жилийн байдлаар давхардсан тоогоор 3847 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан болон бусад зорилтот бүлгийн иргэдэд хөгжлийн цогц үйлчилгээ үзүүлсэн байна.

Уулзалтын үеэр үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд хүний нөөц, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах шаардлагатайг төвийн удирдлагууд болон мэргэжилтнүүд онцлон тэмдэглэв. Мөн хүүхэд багачуудад сэргээн засах болон хөгжлийн үйлчилгээг илүү хүртээмжтэй хүргэх асуудлыг хэлэлцлээ.

САЛБАРЫН 80 ГАРУЙ АЛБАН ХААГЧТАЙ УУЛЗАЖ, САНАЛ ХҮСЭЛТИЙГ НЬ СОНСОВ

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 80 гаруй ажилтан, албан хаагчтай хийсэн уулзалтын үеэр ажиллах орчин нөхцөл, салбарын өмнө тулгамдаж буй асуудал, цаашид хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээний талаар нээлттэй ярилцав. Уулзалтаар орон нутаг дахь үйлчилгээний чанарыг сайжруулах, ажилтнуудын хөдөлмөрлөх нөхцөлийг дэмжих, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах асуудлуудад онцгой анхаарал хандууллаа.

Мөн салбартаа үр бүтээлтэй ажиллаж, мэдлэгчадвар, манлайллаараа хамт олноо тэргүүлсэн шилдэг албан хаагчдыг Монгол Улсын Засгийн газрын шагналаар шагнан урамшуулсан юм.

АХМАД НАСТНЫ ИДЭВХТЭЙ ОРОЛЦООГ ДЭМЖИВ

Томилолтын үеэр Өмнөговь аймгийн Ахмадын аварга шалгаруулах софт волейболын тэмцээний нээлтэд оролцож, ахмад тамирчдад спортын өндөр амжилт хүсэв. Энэхүү арга хэмжээ нь ахмад настнуудын эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжих ач холбогдолтой байлаа.

3. Говийн бүсийн 4 аймгийн Байгаль орчны газар, Усны сав газрын захиргаадад усны чанарын хэрийн хяналт, шинжилгээний багаж, тоног төхөөрөмжийг олгуулах болов

ҮР ДҮН

Өмнөговь аймагт хийсэн томилолтын хүрээнд хүүхэд хамгаалал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээ, нийгмийн хамгааллын салбарын үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, бодит хэрэгцээ шаардлагыг тодорхойлов. Мөн шаардлагатай тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлж, салбарын ажилтнуудын санал хүсэлтийг сонссон нь үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодит үр дүнтэй ажил боллоо.

Говьсүмбэр, Дорноговь, Өмнөговь, Дундговь аймгийн Байгаль орчны газрууд, Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын, Алтайн Өвөр говийн сав газрын захиргаадад ундны усны чанарыг стандартын дагуу тогтмол хянах боломж бүхий хэрийн шинжилгээний багажнууд нийлүүлэх боломж бүрдсэн.

Ер нь Говийн бүс газрын доорх усыг ундандаа ашигладаг. Худгийн усыг ашиглаж л байгаа болбол газрын доорх ус хэрэглэж байгаа гэсэн утгатай тул газрын доорх усыг байнга судалж, шинжилж, шинээр тогтоож байх нь бидэнд чухал юм.

Усны газрын мэдээлснээр усны хэрэглээг дараах байдлаар дүгнэж харж болохоор байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УСНЫ ГАЗАР

МОНГОЛ ОРНЫ УС АШИГЛАЛТЫН БАЙДАЛ

МОНГОЛ ОРНЫ УС АШИГЛАЛТЫН БАЙДАЛ /СҮҮЛИЙН 5 ЖИЛ/


Ус ашиглалт	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
Унд, ахуй	80 сая	83.2 сая	83.2 сая	84.5 сая	86.3 сая
Үйлдвэр, ахуй үйлчилгээ	63 сая	31.3 сая	18.6 сая	16.2 сая	42.6 сая
Хөдөө аж ахуй	305 сая	351.6 сая	353 сая	339.2 сая	338.6 сая
Эрчим хүч	32 сая	13.3 сая	40.8 сая	41.5 сая	46.2 сая
Уул уурхай	90 сая	98.8 сая	95.4 сая	113.4 сая	92.5 сая
Ус ашиглалт жилд	570 сая $м^3$/жил	578 сая $м^3$/жил	591 сая $м^3$/жил	594.8 сая $м^3$/жил	606.2 сая $м^3$/жил

Гэсэн хэдий ч газрын доорх усны нэмэлт судалгаа хангалттай хийгдэхгүй байсаар нийт нутаг дэвсгэрийн 17 хувьд л дата мэдээ цуглуулж байна. Энэ байдлыг залруулахын тул Усны газраас жил бүр усны судалгаанд 10 тэрбум төгрөг төлөвлөж өгөхийг хүссэн хүсэлт ирүүлдэг ч бодитой төлөвлөлтөд багтахгүй явсаар өдийг хүрлээ.

Гэхдээ Говийн бүсэд амьдардаг иргэд унданд хэрэглэж буй усныхаа чанар ямар байгааг, халдваргүйжүүлэх шаардлагатай эсэхийг, унданд хэрэглэж болох эсэх зэргийг шинэ тутам хөгжиж буй технологи ашиглан судлан мэдэх боломж бүрдсэн тул энэ дэвшилтэй хөл нийлүүлэн алхах боломжтой боллоо.

Хүсүүштэй

А Аялал жуулчлалыг хангалттай хөгжүүлэх боломж бүрэн бий



Говийн бүсийн байгаль үгээр хэлж, үзгээр бичишгүй, үнэхээр үзэсгэлэн төгөлдөр гэдэгтэй маргах хүн байхгүй биз. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд ажиллаж байх үеэс байгалийн сайхан тогтцоо жуулчдад үзүүлж, тухай байгалийн тогтоц хэрхэн, яаж, хэзээ үүссэнийг тайлбарлан, шинжлэх ухаанд дуртай, байгалийн сайхныг биширдэг жуулчдыг татдаг байя гэдэг агуулгаар “Геопарк”-ийг хөгжүүлэхийн төлөө ажиллаж эхэлсэн юм.

Олон сайхан байршлыг судалж, салбарын судлаач, эрдэмтэдтэй удаа дараа хэлэлцсэний эцэст Өмнөговь аймгийн Ханбогд, Манлай сумдын нутагт байрлах анхны үндэсний хэмжээний Ханбогд–Шар цавын геопаркийг нээх боломж бүрдсэн байгааг сонсож, харж, гэрчлэхэд их сайхан байгаа. Шар цав бол зөвхөн геологийн онцгой тогтоц бус дэлхийн эртний түүхийг хадгалсан амьд архив, сая сая жилийн өмнөх амьтдын ул мөр, байгаль өөрөө өөрийгөө бичиж үлдээсэн “амьд түүхийн хуудас”-ын баталгаа болсон газар билээ.

Өнөөдрийн байдлаар дэлхий дахинаа ЮНЕСКО-гийн Дэлхийн Геопаркийн сүлжээнд 51 орны 240 гаруй геопарк бүртгэгдэн, байгалийн өвийг хамгаалах, шинжлэх ухааны судалгаа, боловсрол, тогтвортой аялал жуулчлалын уялдааг бэхжүүлэн хөгжүүлж байна.

Ханбогд-Шар цавын геопарк нь ЮНЕСКО-гийн геопаркийн нийтлэг зарчим болох “геологийн өв, боловсрол, тогтвортой хөгжил”-ийн нэгдлийг хангахаас гадна хүн ба байгаль хоёрын олон зуун жилийн хамтын оршихуйн соёл, амьд уламжлалыг зэрэг хадгалж, таниулж байгаагаараа онцлог.

Энэ бүс нутагт үлэг гүрвэлийн мөр, чулуужсан мод зэрэг дэлхийн шинжлэх ухаанд үнэтэй нотолгоонууд төдийгүй, нүүдэлчдийн олон зуун жилийн ахуй соёл, ингэний айраг, ингэ хөөслөх зан үйл зэрэг биет бус өв, мөн ховор амьтдын орших амьд экосистем зэрэг олон үнэт зүйлс нэг дор цогцлон оршиж байна.

Эдгээр нь өнөөдөр бидний нүдэнд ил харагдаж буй бодит байдал боловч Говь нутаг нь үүнээс илүү гүнзгий геологийн нууц, шинжлэх ухааны шинэ нээлтийн боломжийг өөртөө хадгалсаар байна. Иймээс энэ бүс нутаг нь эрдэмтэн судлаачдын тасралтгүй судалгаа, шинэ мэдлэгийн эх сурвалж болох чухал ач холбогдолтой талбар юм.

Энэхүү их үйлсийг бодит ажил хэрэг болгоход мэдлэг, ур чадвар, сэтгэл зүтгэлээ зориулж буй эрдэмтэн судлаачид, төр болон орон нутгийн байгууллагууд, олон улсын түншүүд, хамгийн гол нь энэ нутгийн ард иргэд Та бүхэнд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Ханбогд–Шар цавын геопарк нь ЮНЕСКО-гийн Геопаркийн олон улсын сүлжээнд нэгдэж, Монгол Улс 52 дахь орноор бүртгэгдэхийн ерөөл дэвшүүлье. Монголын говьд мянган жуулчид ирж, дотоодын эдийн засгийг үнэлэхүй хэмжээгээр өсгөж, олон ажлын байрыг шинээр нэмнэ гэдэгт итгэлтэй байна.

Б Сэргээгдэх эрчим хүч

Сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр Дорноговь, Говьсүмбэр, Дундговь, Өмнөговь аймгуудад УИХ-ын гишүүн Мөнхчулууны Энхцэцэг болон Нанзадын Наранбаатар нарын хамтаар 5 дугаар сарын 9-10, 24-25-ны өдрүүдэд ажиллах боломж олдсон юм.

Олон жил яригдаад байдаг хэрнээ олигтой хөдөлж өгдөггүй сэргээгдэх эрчим хүчний ач тус, технологийн шийдэл, төрийн бодлогын шинэчлэлийг танилцуулж ажилласан. Эрчим хүчний салбарын олон аж ахуйн нэгжүүд үзэсгэлэнд нэгдэж, өөрсдийн нэвтрүүлж буй болон гаргаж буй шийдлүүдийг танилцуулж, орчин үеийн дэвшилтэт технологуудыг дэлгэн үзүүллээ. Өнөө хүртэл явж ирсэн салбарын алдаа оноог хүртэл нээлттэй ярилцлаа.



2026-05-24. УИХ-ын гишүүн М.Энхцэцэг, УИХ-ын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар нарын хамтаар Өмнөговь аймагт ажиллалаа.

2020 он гараад Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд нарны илч, тусгац хаана хамгийн их, удаан байдгийг, салхи хаана хүчтэй, тогтвортой байдгийг, усан цахилгаан станцыг хаана барих ёстойг, гүний дулааны эх үүсвэр хаана илүү байгааг судалсан олон улсын тайлан хийгдсэн байдаг. Нар болон салхины хувьд Говийн бүсийг хамгийн тохиромжтой байршил гэж заажээ. Суурь судалгаа нь бэлэн, мэргэжилтнүүд нь бэлэн, аж ахуйн нэгжүүд нь бэлэн байхад төрийн зөв бодлогоор л дэмжих хэрэгтэй байна.

Монголын Алт МАК цемент, шохойн үйлдвэр дөнгөж 1 сарын өмнө ашиглалтад оруулсан 19 мВт-ын нарны эрчим хүчний станцаа танилцууллаа. Бидэнд ажиллах хүч, тэр дундаа чадварлаг хүний нөөц хангалттай байгааг ойлгож, мэдлээ. Уул уурхай, ашигт малтмал, байгалийн нөөцийг анхаарч явдаг миний хувьд эрчим хүчний салбарын өнөөгийн нөхцөл байдлыг илүү сайн мэдэрч, ойлгож авсан өгөөжтэй үүлзалтууд боллоо.

Эрчим хүчний салбар үүл уурхайтай харьцуулшгүй маш олон зөвшөөрөл дунд үйл ажиллагаа нь явдаг салбар юм байна. Үйлдвэржсэн орон болно гэвэл очоод л гацдаг эрчим хүчний эх үүсвэрээ шийдвэрлэх хэрэгтэй байна даа.

The UTimes
ШИНЭЛЭГ. СОНИРХОЛТОЙ. ҮНЭН

Дэлгэрэнгүйг эндээс

Хөгжүүштэй

А Өмнөговь аймагт олон шавь нартай болж байгаадаа баяртай байна

Миний бие Байгалийн ухааны докторын зэрэг хамгаалсан хүний хувьд ШУТИС-ийн зөвлөх профессороор ажиллаад 2 дахь жилтэйгээ золгож байна. Чуулганы завсарлагаагаар Өмнөговь аймаг дахь салбар сургуульд “Ашигт малтмалын эдийн засаг” хичээлийг уул уурхайн мэргэжил эзэмшихээр 3 дугаар дамжаанд суралцаж буй оюутнуудад орж байгаадаа баяртай байгаа.


Хичээлээр Монгол Улсын ашигт малтмалын хэтийн төлөв, Ашигт малтмалын эдийн засаг, Монгол Улсад элбэг тохиолддог ашигт малтмалын төрлүүд, үүсдэг нөхцөл, Ашигт малтмалын нөөц, Нөөц бүхий ордыг үнэлэх шалгуурууд, Орд ашиглах газарзүй-эдийн засаг, экологийн нөхцөл тодорхойлох хүчин зүйлүүд, Уул уурхайн үйлдвэрийн хөрөнгө, Үндсэн болон эргэлтийн хөрөнгө, ашиглалтын үзүүлэлтүүд, Уул уурхайн үйлдвэрийн ажиллагсад, түүний бүтэц, Уул уурхайн үйлдвэрийн цалин хөлс, нэмэгдэл, Уул уурхайн төсөлд хийх техник, эдийн засгийн үндэслэл, Уурхайн оновчлол, эдийн засгийн үр ашгийг тооцоолох нь, Уул уурхайн үйлдвэрийн бүтээмж, Уул уурхайн үйлдвэрийн зардал, түүний бүтэц, Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт, Уул уурхайн салбарын эрсдэлийн талаар ордог.

Хариуцлагатай уул уурхай хөгжих ёстой.



ШУТИС-ийн харьяа Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн “Уул уурхайн ашиглалтын инженер” мэргэжлийн анхны төгсөгчид

Б Үгийн сүлжээ



ХӨНДЛӨН:

1. Монгол Улсын үрт хугацааны хөгжлийн бодлого
2. Судалгааны үр дүнг эдийн засагт нэвтрүүлэх үйл ажиллагаа
3. Үндэсний эрдэм шинжилгээний бүтээлийн платформ
4. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага
5. Судалгааг дэмжих мөнгөн эх үүсвэр
6. Байгуулахаар тусгасан төв
7. Тендерт оролцоход чөлөөлөхөөр тусгасан зүйл
8. Судалгааны ажлыг нэгтгэдэг үндэсний платформ

БОСОО:

1. Шинжлэх ухааны үндсэн үйл ажиллагаа
2. Хөгжүүлэхээр тусгасан дэвшилтэт технологи
3. Өндөр технологийн нэг төрөл
4. Бүтээл хадгалах нэгдсэн сангийн үндэс
5. Судалгааны тайлан ямар байх ёстой вэ?
6. Хуулийн төсөлд дурдсан их сургуулийн төрөл
7. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг дэмжих байгууллага
8. Хөгжлийн бодлогод дурдсан технологи

Хууль санаачлагч:
Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Д.Рэгдэл, Г.Хосбаяр.

В Puzzle

1.БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТҮЛХҮҮР ҮГС

У	Д	Н	Ь	Л	Л	Т	Т	К	Ъ	С	Э	М	Д	У
Е	Г	Э	Ю	Э	Б	Ю	Б	Ъ	К	В	Э	Я	Д	Л
Ш	Ө	Г	Ь	Д	Ы	А	И	А	Ы	Д	Г	Г	Д	И
Х	Х	Р	Ө	О	Т	З	Й	Ө	Й	Р	Л	Щ	Э	Е
В	И	И	Д	Щ	М	Ы	З	Г	М	Я	Э	Ц	Ь	Ы
Г	Ж	Ю	Ц	Р	Л	Э	Ч	Ф	А	Ф	Н	В	И	Т
А	С	Е	Е	Ь	Щ	Ф	Д	Б	Ү	Л	Ү	Щ	Щ	Ө
О	М	С	Г	Д	Й	Ч	В	Э	Л	О	Ь	Ө	Я	С
Ө	Б	Ю	М	Я	Э	Щ	Б	Ь	Э	Ъ	Х	Л	Е	Ө
В	К	Х	У	У	Л	И	Й	Н	З	Л	Ы	Г	З	Л
Е	Э	Й	Ь	Ш	Ы	Э	Щ	Ж	Ю	Ж	Э	Ш	Й	Б
Э	Р	Ч	Т	Д	Ц	Э	З	В	Й	П	Т	Л	Н	З
М	С	Н	Ө	Л	Ө	Ө	Л	Ө	Л	Я	Е	Я	У	Ф
К	П	П	Л	Н	В	О	Р	Ч	И	Н	О	Д	Ю	Ф
Ц	А	Й	Н	Л	Ч	Ф	Ж	Э	Х	Ы	Х	В	Ф	М

Доорх 8 үгийг хайгаад олдсон үгийн хажууд ☑ тэмдэглээрэй.

Хайх үгс:
- ☑ ҮНЭЛГЭЭ
- ☑ БАЙГАЛЬ
- ☑ НӨЛӨӨЛӨЛ
- ☑ ОРЧИН
- ☑ ХУУЛИЙН
- ☑ ТӨСӨЛ
- ☑ ИРГЭН
- ☑ МЭДЭЭЛЭЛ

1.ОЛОН ХҮҮХЭД ТӨРҮҮЛЖ ӨСГӨСӨН ЭХИЙГ УРАМШУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТҮЛХҮҮР ҮГС

К	А	О	К	К	В	У	Ю	Ц	Й	Ш	К	Ф	У	Ү	Я	Ч
Х	Ш	Я	Ш	Х	Э	У	Э	И	Ө	А	У	Л	П	Н	Б	Б
Э	А	Э	Ж	А	Х	К	Я	Р	Т	Б	У	Х	З	Й	Я	Р
С	О	Л	Й	М	Ф	Ү	П	Д	Х	С	Д	Е	Ш	И	З	И
Ш	Т	П	О	Л	В	Л	Ү	Я	А	И	Ш	Э	Я	Х	Р	Ж
Ү	Х	О	В	Ө	Л	Ү	В	Х	О	Ө	Й	К	Ф	Э	Ж	Т
Я	П	Ц	Ц	Т	Э	Б	А	Ү	Э	Т	А	Н	Р	К	Ө	Х
У	Ф	Л	Л	Ф	Е	Р	О	Н	Э	Д	У	С	П	Р	Г	У
А	Ж	Е	А	С	Ю	Э	У	Й	Х	Р	Л	Ю	Ө	Й	Ф	К
Ч	Т	Ж	Л	Ч	Р	Г	Ю	Г	С	Ц	Ю	Л	У	Й	У	Й
Н	Х	Л	У	Д	Ө	Э	Т	Й	Л	Л	Т	Л	Ө	Ч	Н	Р
Р	Т	Д	У	Ж	Л	Я	З	Н	О	А	М	Е	Я	Ү	Ц	Ф
А	Е	Г	Ш	С	Ф	С	К	Г	Д	О	М	О	Ү	Д	Ф	Ю
Ч	Р	Ч	М	У	В	Ө	Т	В	О	С	Ө	Д	В	Ж	В	Ц

Доорх 8 үгийг хайгаад олдсон үгийн хажууд ☑ тэмдэглээрэй.

Хайх үгс:
- ☑ УРАМШУУЛАЛ
- ☑ ЭХИЙН
- ☑ ТӨРӨЛТ
- ☑ ЭРХИЙН
- ☑ ХҮҮХЭД
- ☑ ОДОН
- ☑ ТЭГШ
- ☑ ГЭРБҮЛ